



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙН
ЗАРИМ ОЙЛГОЛТЫГ
ТАЙЛБАРЛАН ХЭРЭГЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ИХ/00/2023/01/02

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2023.01.12

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
1.1. Даатгал, түүний ач холбогдол, эрх зүйн зохицуулалт.....	5
1.2. Даатгалын төрөл, тодорхойлолт	7
1.3. Монгол Улсын даатгалын эрх зүйн хөгжилд тулгамдаж буй асуудал	8
1.4. “Өвчин”-ийг тодорхойлох нь.....	10
1.5. Гэнэтийн ослыг тодорхойлох нь	12
Хоёр. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	17
2.1. ИБУИНХУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт	17
2.2. БНСУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт	21
2.3. Япон Улсын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт.....	23
2.4. Австралийн Холбооны Улсын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт	24
2.5. ХБНГУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт	26
2.6. ОХУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт	28
ДҮГНЭЛТ.....	33
ЭХ СУРВАЛЖ	37

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИБУИНХУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хант Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХК	Хувьцаат компани
ШССМХ	Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

УДИРТГАЛ

Судлах зүйл

Судалгааны ажлын хүрээнд зарим нэр томъёог анагаах ухааны болон эрх зүйн хувьд (тэр дундаа даатгалын эрх зүйд) хэрхэн тодорхойлдог талаар судалж, дотоодын эрх зүйн хэм хэмжээ болон харьцуулсан судлахаар сонгон авсан улсын эрх зүйн хэм хэмжээнд даатгалын эрх зүй, даатгалын ач холбогдлыг дэлгэрүүлэн судлахын зэрэгцээ “өвчин”, “гэнэтийн осол”, “осол” гэх ойлголтууд туссан эсэх, тийм бол тэдгээрийн агуулгыг дэлгэрүүлэн судаллаа.

Судалгааны хамрах хүрээ

Судлах зүйлийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, ИБУИНХУ, БНСУ, Япон Улс, Австралийн Холбооны Улс, ХБНГУ, ОХУ-ыг сонгон даатгалын эрх зүйн холбогдох ойлголтыг судлав.

Судалгааны арга зүй

Судалгааг хийж хийж гүйцэтгэхдээ харьцуулан судлах, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх арга зүйг ашигласан.

Судалгааны бүтэц

Тус судалгаа нь Даатгалын эрх зүйд хамаарах зарим ойлголтын талаар товч, Харьцуулсан судалгаа, Дүгнэлт, Эх сурвалж гэсэн хэсгээс бүрдэнэ.

Нэг. ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙД ХАМААРАХ ЗАРИМ ОЙЛГОЛТЫН ТАЛААР ТОВЧ

1.1. Даатгал, түүний ач холбогдол, эрх зүйн зохицуулалт¹

Хүн бүр амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө хамгаалахын тулд учирч болох эрсдэлээс сэргийлдэг хэдий ч “гай газар дороос” гэдэг шиг аливаа өвчин зовлон, аюул осол хэлж ирдэггүй хийсэж ирдэг. Энэ үед хүн сэтгэл санааны, бие махбодын, эд хөрөнгийн хохирол амсаж, түүнийг барагдуулах, даван туулахад тодорхой хэмжээний санхүүгийн дарамт үүсдэг.

Иймээс аливаа хувь хүн, албан байгууллагын хэвийн байдлыг алдагдуулах, санамсаргүй, эрсдэл дагуулсан үйл явцаас үүсэх хохирлыг бууруулах, нөхөх санхүүгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол даатгал² юм.

Хүмүүс хэсэг бүлгээрээ дундын сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах нь даатгалын үндсэн хэлбэр юм.

Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг бөгөөд учирсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхүйц байх боломжтой. Үүнтэй адил **даатгал бол бага зардал гарган их хэмжээний хохирлоос хамгаалагдах боломж** буюу хариуцлага, хамгаалалт, амар тайван байдлыг эрэлхийлсэн эрсдэлийн удирдлагын энгийн шийдэл гэж ойлгож болно.

Гэнэтийн эрсдэл хэнд ч, хэзээ ч тохиолдох магадлалтай тул түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх, шилжүүлэх, хүлээн зөвшөөрөх зэрэг арга хэмжээг авч болох бөгөөд учирч болзошгүй хохирлыг бусдад шилжүүлэх буюу даатгалд хамрагдах боломж байдаг.

Эрсдэлийг даатгагдах болон даатгагдахгүй эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой эрсдэлийг даатгагдах эрсдэл гэдэг. Даатгуулж болох болон даатгуулж үл болох эрсдэлийн төрлийг үзүүлбэл:

Даатгуулж болох эрсдэлийн төрлүүд	Даатгалд хамрагддаггүй эрсдэлийн төрлүүд
Хувь хүний эрсдэл - Амь нас, эрүүл мэнд учирч болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: автомашины осолд өртөх, өвчин тусах г.м	Элэгдэл, хорогдол
Таны эд хөрөнгөд бүрэн буюу хэсэгчлэн хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: хулгайд юмаа алдах, орон гэр нь гал түймэрт өртөх г.м	Техникийг шалган турших явцад гарсан хохирол
Хариуцлагын эрсдэл - Аливаа хариуцлагагүй болон санаандгүй үйлдлээс болж бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэлүүд. Жишээ нь: автомашин жолоодож байхдаа бусдыг гэмтээх, эд хөрөнгөд нь хохирол учруулах г.м	Хувь сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл

Даатгал гэдгийг үг зүйн талаас нь тайлбарлан тодорхойлсон монгол хэлний эх тайлбар тольд “даатгал гэдэг нь даатгах үйлийн нэр, байгалийн гамшиг, золгүй явдал тохиолдох, мөн нэр заан тодорхойлсон үйл ажиллагаатай холбогдон гарах хохирлыг нөхөх зорилгоор тогтоосон журмын дагуу байгуулсан мөнгөн сан, түүнээс авч зарцуулах бүх

¹ Даатгалын ач холбогдол (гарын авлага), Монгол банк, 2020 он.

<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/26.pdf> Сүүлд үзсэн: 2023.01.02.

² Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагааг хэлнэ.

ажиллагааны цогц; гэнэтийн осол, байгалийн аюулын хохиролд өртөгсдөд үзүүлэх нөхөн төлбөр, тусламжийн баталгаа”³ гэж тодорхойлсон бол эрх зүйн хувьд даатгалыг тодорхойлохдоо “даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдэлээ даатгуулж даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох итгэлцэл дээр суурилдаг үйл ажиллагаа юм”⁴ гэжээ.

Даатгалын үйл ажиллагаа нь даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй харилцаа болохын хувьд энэхүү харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогчид, төрийн байгууллагууд оролцдог.

Даатгалын тухай хуульд зааснаар даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яам даатгалын бодлогыг, СЗХ даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлдэг бол, “Даатгалын тухай хууль” болон “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль”-ийн дагуу даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогчид буюу даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч нь СЗХ-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.

Даатгалын эрх зүйн харилцааг доорх зургаар үзүүлбэл:



Тухайн харилцаанд хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээ:

	Даатгалын ангилал, төрөл	Тодорхойлолт	Жишээ
Ангиллаар нь	Ердийн даатгал ⁵	Аливаа гэнэтийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эдийн бус ашиг сонирхолд учрах эрсдэлээс	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, эд хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын,

³ <https://mongoltoli.mn/dictionary/detail/29026>, (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁴ Даатгалын ач холбогдол (гарын авлага), Монгол банк, 2020 он.

<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/26.pdf>, (Сүүлд үзсэн: 2023.01.02).

⁵ Нэг жил хүртэл хугацаатай хийгддэг даатгал.

		хамгаалах, <u>богино хугацаатай, амьдралын бус даатгал</u>	газар тариалангийн, мал амьтдын даатгал г.м
	Урт хугацааны даатгал ⁶	Хүний амь нас, эрүүл мэндэд учрах эрсдэлээс хамгаалах, амьдралын баталгаатай холбоотой санхүүгийн хүндрэлийг шийдвэрлэх, <u>урт хугацаатай, амьдралын даатгал</u>	Хугацаат амьдралын, насан туршийн, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн г.м
Төрлөөр нь	Албан журмын ⁷	Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
	Сайн дурын ⁸	Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал	Хуульд заавал даатгуулах гэж зааснаас бусад даатгал

1.2 Даатгалын төрөл, тодорхойлолт⁹

Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд даатгалын бүтээгдэхүүн нь даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл: хүүхдийн гэнэтийн ослын даатгал, хашаа, байшингийн даатгал, гадаадад зорчигчийн даатгал, хүүхдийн боловсролын хуримтлалын даатгал г.м.

Үүнээс гадна ерөнхий байдлаар дараах даатгалын төрлүүд байдаг:

Даатгалын төрөл	Агуулга
Гэнэтийн осол¹⁰, эмчилгээний зардлын даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна.

⁶ Нэг жилээс дээш хугацаатай даатгал. **Амьдралын даатгалын төрлүүд урт хугацааны даатгалд орно.** Амьдралын даатгал гэдэгт “тэтгэврийн насанд хүрээд даатгалаас нөхөн төлбөрөө авдаг, хэрвээ тэтгэвэрт гарахаасаа өмнө хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас алдсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг авдаг, даатгуулагч нь нас барвал өв залгамжлагчид нөхөн олговор олгодог” даатгалыг ойлгох ба гадаад орны өндөр настай иргэд залуу байхдаа амьдралын даатгалд даатгуулаад тэтгэвэртээ гарахдаа нөхөн төлбөрөө авч, амьдралын эцсийн мөчөө хүртэл санхүүгийн хувьд эрх чөлөөтэй амьдардаг байна.

⁷ Хуульд заасны дагуу иргэд заавал даатгуулбал зохих даатгалын төрөл. Зорчин явагчдын гэнэтийн ослын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалууд орно.

⁸ Даатгуулагч сайн дурын үндсэн дээр даатгуулдаг даатгалын төрөл.

⁹ <https://www.sankhuuginbolovsrol.mn/cdn/pdf/Huvi%20hun%20buleg14.pdf>. (Сүүлд үзсэн: 2023.01.02).

¹⁰ **Энэхүү даатгал нь даатгуулагч ажлын цагаар, ажлын байран дээрээ ажил үүргээ гүйцэтгэж байх үед эсвэл Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаана ч, ямар ч нөхцөлд гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдах, хэсэгчлэн болон бүрэн алдах, нас барах тохиолдлуудад даатгуулагч эсвэл түүний ар гэрийнхэнд нөхөн төлбөр олгох зорилготой даатгал юм. Гэнэтийн ослын даатгал гэдэгт даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдах, нас барах тохиолдолд нөхөн төлбөр олгох зорилго бүхий даатгалыг ойлгох ба энэ даатгалд гэнэтийн, үйлдвэрлэлийн, зам тээврийн болон ахуйн осол, бусдын санаатай ба санамсаргүй үйлдлээс үүссэн эрүүл мэнд, амь насны хохирол гэх мэт эрсдэлээс хамгаалж даатгуулдаг. Гэнэтийн ослын даатгал нь олон төрөлтэй байна. Үүнд: 1. Ажиллагсдын гэнэтийн ослын даатгал; 2. Иргэдийн гэнэтийн ослын даатгал; 3. Гадаадын жуулчдын гэнэтийн ослын даатгал; 4. Гадаадад зорчигчдын гэнэтийн ослын даатгал; 5. Уралдааны морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал; 6. Хүүхдийн гэнэтийн ослын даатгал; 7. Оюутны гэнэтийн ослын даатгал; 8. Тамирчин, жүжигчдийн гэнэтийн ослын даатгал гэх мэт. Энэ даатгалын хураамжийг жилд 1 удаа даатгалын үнэлгээнээс тодорхой хувиар бодож тооцдог. Жишээ нь: оюутны гэнэтийн ослын даатгалын хураамж даатгалын үнэлгээний 1 хувь байдаг.**

Авто тээврийн хэрэгслийн даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна.
Жолоочийн хариуцлагын даатгал	Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахад даатгагчаас хохирогчид мөнгөн төлбөр төлөх, хохирогчийн эрхийг хамгаалах нөхцөл бүхий даатгал.
Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна.
Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч, эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна.

Дээр дурдсанаас гадна тамирчдын буюу спортын даатгал, гэр, хашаа байшингийн даатгал, орон сууцны даатгал, лангуу түрээслэгч, жижиг худалдаа эрхлэгчдийн даатгал, малын эрсдэлийн даатгал гэх мэт төрлүүд мөн байж болно.

Түүнчлэн даатгалын нэг төрөлд хамаарах “амь даатгал”-ыг монгол хэлний тайлбар тольд **амь даатгал (байгалийн болон бусад бүх төрлийн гэнэтийн аюул осолд нэрвэгдэхэд үзүүлэх төлбөр)** гэж тодорхойлсон байна.

Мөн **“хугацаат амь насны даатгал” гэсэн даатгалын төрөл байх ба энэ төрлийн даатгал нь аливаа өвчин болон гэнэтийн ослын улмаас амь нас эрслэх тохиолдолд ар гэрт нь нөхөн төлбөр олгосноор гэр бүлийн гишүүдийг учирч болзошгүй санхүүгийн гэнэтийн эрсдэлээс хамгаалах даатгал юм**¹¹ гэжээ.

1.3. Монгол Улсын даатгалын эрх зүйн хөгжилд тулгамдаж буй асуудал¹²

Монгол Улсад 2021 оны байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 57, даатгалын хохирол үнэлэгч 25 компани, даатгалын 2403 төлөөлөгч даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2017-2021 оны хооронд дунджаар жилийн 15.8 хувиар өсөж, 425.4 тэрбум төгрөгт хүрээд байгаа бөгөөд **нийт хөрөнгийн 84.2 хувийг ердийн даатгалын компаниуд**, 13.6 хувийг давхар даатгалын компани, **2.2 хувийг урт хугацааны даатгалын компани** тус тус эзэлж байна.

¹¹ National Life Insurance, Байгууллагад зориулсан хуримтлал болон амь насны даатгалын танилцуулга. (Цахим хуудас: <https://nlic.mn/>)

¹² Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, 2022 он, https://mof.gov.mn/files/uploads/discussion/1.1.%D0%94%D0%A2%D0%A5-%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D0%BD_%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0_0522_.pdf, (Сүүлд үзсэн: 2023.01.02).

Даатгалын хураамжийн орлого 2017-2021 оны хооронд жилд дунджаар 17.0 хувиар өсөж 243.3 тэрбум төгрөгт хүрсэн ба ердийн даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 99.3 хувийг, урт хугацааны даатгалын компани 0.7 хувийг бүрдүүлээд байна. Ердийн даатгалын компаниудын нийт хураамжийг даатгалын хэлбэрээр авч үзвэл, хөрөнгийн даатгал 27.1 хувийг, жолоочийн хариуцлагын даатгал 15.5 хувийг, авто тээврийн хэрэгслийн даатгал 20.3 хувийг, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 12.9 хувийг тус тус эзэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар даатгалын компаниуд 1,209,243 даатгалын гэрээг байгуулж ажилласан бөгөөд үүний 57.1 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 10.45 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал, 11.9 хувийг хөрөнгийн даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөр 2017-2021 оны хооронд жилд дунджаар 15.9 хувиар өсөж 2021 оны байдлаар 68.9 тэрбум төгрөгт хүрсэн ба ердийн даатгалын компаниуд нийт нөхөн төлбөрийн 97.5 хувийг, урт хугацааны даатгалын компани 2.5 хувийг бүрдүүлээд байна.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо: СЗХ-ны 2020.10.07-ны өдрийн 936 дугаар тогтоолоор өгсөн үүрэг даалгавар, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага хангагдаагүй буюу төлбөрийн чадваргүй болсон тул “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Үүнтэй холбогдуулан зөвхөн шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын хүрээнд авч үзэхэд иргэд, даатгуулагчид (1 байгууллага, 5 иргэн) нийт 120,760,316.00 төгрөгийн нөхөн төлбөрийг тус компаниар гаргуулж чадахгүй, хохироод байгаа юм. Харин 2019-2021 оны хооронд СЗХ-д “Соёмбо даатгал” ХХК-тай холбогдох 43 өргөдөл гомдол ирүүлсэн бөгөөд нийт 40 иргэн байгууллагын 297.3 сая төгрөгийн хохирлыг тус компани барагдуулаагүй байдалтай байна.

Мөн олон улсын сайн туршлагыг авч үзвэл, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн 26 оронд (2013 оны байдлаар) даатгагч төлбөрийн чадваргүй болох, дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий даатгалын салбарын эрсдэлийг бүхэлд нь (нэгдсэн схем - Солонгос, Испани, Их Британи, хэд хэдэн схемийн хүрээнд Канад, Франц, Япон, АНУ), хэсэгчлэн (зөвхөн амьдралын бус даатгал – Австрали, Дани, Норвег, зөвхөн амьдралын даатгал – Австри, Герман, Грек) эсхүл жолоочийн хариуцлагын даатгал, ажилчдын гэнэтийн осол, гуравдагч этгээдийн хариуцлага, хувийн эрүүл мэндийн даатгал зэрэг нэр бүхий даатгалын эрсдэлийг хамарсан Даатгуулагчийн хамгаалалтын схем (Policyholder Protection Scheme) байдаг байна.

Иймд даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоодын практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг бий болгосноор олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэх, салбарын нэр хүнд өсөх зэрэг эерэг нөлөөллийг бий болгоно гэжээ.

Түүнчлэн хөдөлмөрийн чадвараа алдах, зарим төрлийн өвчин эмгэг болон урт наслалттай холбоотой удаан хугацаанд үүсэж болох хувь хүний санхүүгийн эрсдэлүүдийг даатгах үйл ажиллагаа явуулдаг. Манай улсын хувьд ердийн болон урт хугацааны даатгалын ангиллын зааг ялгааг хуулиар тодорхой заагаагүйгээс урт хугацаанд хийгдэх зарим даатгалын хэлбэрийг ердийн даатгалын компаниуд эрхэлж байгаа нь нэг талаас урт

хугацааны даатгалын үйл ажиллагааны өсөлтийг хязгаарлах, нөгөө талаас даатгуулагчдад буруу ойлголт төрүүлэх эрсдэлийг дагуулж байна.

2016- 2020 оны хооронд анхан шатны шүүхийн 50 шийдвэрийг судалж үзэхэд 9 нь ипотекийн зээлийн даатгалтай холбоотой маргаан байв. **Ипотекийн зээлийн гэрээ нь 10-аас дээш жилээр хийгдэж байгаа боловч урт хугацаанд хувь хүнд үүсэх өвчин эмгэг зэргийг гэнэтийн ослын даатгалын тохиолдолд тооцдоггүй нь даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэж буй маргааны нэг шалтгаан болж байна.** Тухайлбал, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо мэдээг сүүлийн 3 (2018-2020) жилийн байдлаар авч үзвэл даатгалын салбарт хамааралтай нийт өргөдөл, гомдолд орон сууцны зээлдэгчийн эрсдэлийн даатгалтай холбоотой өргөдөл, гомдлууд нь 3-т буюу жолоочийн хариуцлагын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгалын дараа орж байна.¹³

Иймд урт хугацаанд даатгуулах нь тодорхой эсвэл хууль, журмаар шаардсан бөгөөд хүний амь нас, орлоготой холбоотой эрсдэлийг тус ангилалд оруулах нь даатгуулагчийн эрх ашигт нийцэх тул ангиллын нэршлийг иргэдэд илүү ойлгомжтойгоор буюу амьдралын болон ердийн (амьдралын бус) гэж томъёолох хэрэгцээ үүсэж байна. Түүнчлэн энэ нь амьдралын даатгалын үйл ажиллагааг шууд бус хэлбэрээр дэмжинэ.

1.4. “Өвчин”-ийг тодорхойлох нь

Хугацаат амь насны даатгал

Амь насны даатгал нь аливаа өвчин болон гэнэтийн ослын улмаас амь нас эрсдэх тохиолдолд ар гэрт нь нөхөн төлбөр олгосноор гэр бүлийн гишүүдийг учирч болзошгүй санхүүгийн гэнэтийн эрсдэлээс хамгаалах даатгал юм.

Даатгалд хамрагдсанаар:

- Даатгалын хамгаалалт дэлхий дахинд 24 цагийн туршид үйлчилнэ.
- Бүх төрлийн өвчин болон гэнэтийн ослын улмаас нас барах эрсдэлийг хамгаална.
- Гэр бүлийн гишүүддээ өв хөрөнгө үлдээж, баталгаатай орлого бий болгоно.
- Нэмэлтээр хөдөлмөрийн чадвар алдалт болон эмнэлгийн мөнгөний даатгалын хамгаалалт авах боломжтой.
- Даатгалын хураамж хямд, урт хугацаанд тогтмол хэмжээгээр төлөхөөс гадна сар, улирал, хагас жилээр төлөх боломжтой.

Өвчний мөн чанарын тухай авч үзвэл: Эртний Грекийн анагаах ухаанд хүний биеийн шингэн шүүс (цус, салс, хар цөс, шар цөс)-ний хэвийн харьцаа хямран өөрчлөгдөхийг өвчин гэж тодорхойлсон шингэний гарлын тухай урсгал, таамаглал биеийн эгэл бүтэц цулын байршил, дараалал алдагдсаныг өвчин хэмээн үзсэн (Демокритын) урсгал чиглэлүүд гарч байсан байна¹⁴.

¹³ Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа, 2018, 2019, 2020.

¹⁴ Ц.Цэцэгмаа, Б.Оюунбат-Эмгэг үйл судлал, 2004 он, 10 дахь тал

XIX-XX зууны эхэн үеийн томоохон философич болон эмгэг судлаачдын өвчний тухай тодорхойлолтууд нь орчин үеийн өвчин судлалын (Нозологи) үндэслэл болсон юм.

Гадаад улсын зарим судлаачид “өвчин”-г дараах байдлаар тодорхойлжээ:

- К. Бернар “Хэвийн биш нөхцөл дэх амьдралыг өвчин”,
- Р. Вирхов “Өвчин гэдэг нь эсийн гэмтэл юм. Хүний бие махбод эсээс тогтдог буюу эсийн бөөгнөрөл хуримтлал юм. Тиймээс амьдрал, өвчтэй болон эрүүл байх тэрчлэн үхэл ч түүнээс хамаарна”,
- И.П.Павлов “Өвчин гэдэг нь зөвхөн хэсгийн гэмтэл өөрчлөлт төдийгүй бүхэл бүтэн бие махбод, биеийн хамгаалах чадвар, тохируулга, зохицуулга хамрагдан өөрчлөгдсөнийг өвчин”,
- А. А. Остроумов “Хүрээлэн байгаа орчиндоо хүний бие махбодын дасан зохицох чадвар алдагдахыг өвчин”,
- И.М.Сеченов “Гадаад орчны эмгэг сэдээгч (гэмтээгч) цочрол үйлчилснээс өвчин үүснэ”,
- Д.Е.Альперн “Өвчин үүсгэгч хүчин зүйлийн нөлөөлөлд хүний биеийн дасан зохицох чадвар алдагдахад үүсдэг эрхтэн тогтолцооны бүтэц болон үйл ажиллагааны, мөн хөдөлмөрлөх чадвар буурахад илэрдэг биологийн нийлмэл үйл явцыг өвчин”,
- А.Д.Адо “Өвчин гэдэг нь гадаад орчны гэмтээгч хүчин зүйлүүдийн үйлчлэлд бие махбодоос хариулж буй ерөнхий урвал, буюу хүрээлэн буй орчны нөлөөнд дасан зохицох чадвар алдагдахад үүсдэг эрхтэн эдийн бүтэц, үйл ажиллагааны өөрчлөлтөөр илэрдэг чанарын шинэ үйл явц” гэж тус тус өөрсдийнхөөрөө тодорхойлжээ¹⁵.

Өвчтэй байна гэдэгт:

- Өвчин үүсгэгч ямар нэг хүчин зүйл биед нөлөөлж үйлчилсэн *байх /ямар нэг шалтгаангүйгээр өвчин үүсэхгүй/*,
- Гаднын нөлөөлөл, өвчин үүсгэгч хүчин зүйлийн үйлчлэлд бие махбодын хамгаалах болоод дасан зохицох чадвар буурсан байх,
- Сэтгэл санааны таагүй байдал, ямар нэг зовуурь, шаналгаатай байх,
- Бие махбод бүхэлдээ буюу эсвэл аль нэг эрхтэн тогтолцооны хэвийн үзүүлэлтүүд өөрчлөгдөж, ямар нэг гэмтэл согог, эмгэг өөрчлөлт илэрсэн байх,
- Биеийн чалх тамир, хөдөлмөрийн чадвар буурах зэрэг хэвийн төлөв өөрчлөгдсөн зэргийг үндэслэл болгон тодорхойлно.

Өвчний эмгэг жамын тухай ойлголт:

Өвчний эмгэг жам гэдэг нь аливаа өвчний явц, хөгжих жам зүйг судалдаг эмгэг үйл судлалын ухааны нэг үндсэн хэсэг мөн. Өвчний эмгэг жамын тухай ерөнхий ойлголт нь өвчин үүсэж хөгжих жам, түүний ерөнхий зүй тогтлын тухай анагаах ухааны онолын суурь ойлголт юм.

Өвчний эмгэг жамын тухай ойлголтын мөн чанарыг эмгэг жамын хүчин зүйл тодорхойлно. Ямар нэг өвчний явц, хөгжил нь өөрийн дотоод зүй тогтол, эмгэг жамын хүчин зүйлүүдээр нөхцөлдөн явагддаг. Эмгэг жамын хүчин зүйл гэсэн ойлголтод өвчин үүсгэх шалтгаан¹⁶ үйлчилснээс хойш бие махбодод гарч буй өөрчлөлтүүдийг хамааруулан авч үздэг.

¹⁵ Ц.Цэцэгмаа, Б.Оюунбат-Эмгэг үйл судлал, 2004 он, 11-12 дахь тал

¹⁶ **Өвчний шалтгаан гэдэгт өвчний мөн чанар, өвөрмөц шинж төлөвийг бүрэн нөхцөлдүүлэн тухайн өвчнийг үүсгэж байгаа, түүний оролцоо нөлөөгүй бол уг өвчин үүсэхгүй байх тийм хүчин зүйлийг хэлнэ.** Өвчний шалтгааныг гадаад, дотоод гэж ангилах бөгөөд гадаад шалтгаан нь хүрээлэн байгаа гадаад орчноос бие махбодод нөлөөлж өвчин үүсгэж байгаа хүчин зүйлийг хэлнэ. Дотор нь механикийн, физикийн, химийн, биологийн, нийгмийн, сэтгэл санааны гэсэн төрөл зүйлд

Өвчний эмгэг жамд гол зангилаа өөрчлөлт байх бөгөөд энэ нь тухайн өвчний өвөрмөц төлөв болон бусад бүхий л өөрчлөлтүүдийг нөхцөлдүүлэх нөлөө бүхий давамгайлсан өөрчлөлт юм. Өвчний явц, эмгэг жамыг шалтгаан хамааралт өөрчлөлтүүд буюу шалтгаан үр дагаврын тасралтгүй үргэлжлэн явагдах гинжин холбоо хэмээн үздэг. Жишээ нь: Механик хүчин зүйл- бэртэл- цус алдалт- цусны эргэлтийн хямрал-гипоксидоз-хордлого үүсгэх гэхчлэн холбогдоно¹⁷.

Зарим өвчний үед эмгэг жамын хүчин зүйлүүд нь битүү цагирган хэлхээг үүсгэж тэр нь тухайн өвчний явцыг хүндрүүлэн гүнзгийрүүлдэг. Энэ байдлаас гагцхүү эмгэг жамын эмчилгээг оновчтой, туйлбартай явуулсны үр дүнд гарна. Жишээ нь: Цусны даралт ихдэх өвчний үндсэн шинж тэмдэг нь артерийн даралт тогтвортой ихдэх үзэгдэл юм. Энэ өвчний үед артерийн их ба бага даралт тогтвортой ихдэх нь шалтгаан хамааралт эмгэг жамын хүчин зүйлүүдийн битүү хэлхээгээр нөхцөлдөн явагдана. Иймд өвчний явц дахь шалтгаан хамааралт өөрчлөлтүүд /эмгэг жамын хүчин зүйл/ нь тухайн өвчний шинж тэмдэг, хам шинжүүдээр илэрч өвчний эмнэл зүйг тодорхойлдог байна¹⁸.

Өвчний ангилал, үе шат

Өвчнийг ангилах олон янзын зарчим байдаг. Тухайлбал:

- Өвчнийг үүсгэж байгаа шалтгаанаар нь: Халдварын, халдварын биш өвчнүүд, бэртэл гэмтлийн, мэргэжлийн, туяаны гэх мэт;
- Өвчний мөн чанар жам зүйг үндэслэж ангилах: Харшлын, хавдрын, хордлогын, үрэвсэлт өвчнүүд гэх мэт;
- Өвчний явц, үргэлжлэх хугацаагаар нь: цочмог, цочмогдуу, архаг өвчин гэж хуваана. Цочмог явцтай өвчинд хэдэн минут, цаг, хоногоос 2 долоо хоног, 2 долоо хоногоос нэг сар хагас үргэлжлэх цочмогдуу, сар хагас түүнээс дээш хэдэн сар жил үргэлжлэх өвчнийг архаг өвчин гэнэ;
- Өвчний үе дэх эмгэг үйл явцын байршлаар нь ангилах: Зүрх судасны, амьсгалын тогтолцооны, арьсны, нүдний, мэдрэлийн, дотоод шүүрлийн булчирхайн гэх мэт,
- Өвчтөний нас, хүйсээр нь: хүүхдийн, насанд хүрэгчдийн, өндөр настны, эмэгтэйчүүдийн;
- Биеийн хөгжлийн аль үед үүссэнээр нь удамшлын, төрөлхийн, олдмол өвчин гэж ангилдаг байна.

1.5. Гэнэтийн ослыг тодорхойлох нь

Гэнэтийн осол гэдэг нь ерөнхий агуулгаараа “осол” гэсэн ойлголтод хамаарах тул “осол” гэсэн эрх зүйн ойлголтыг нэн тэргүүнд тодруулах шаардлагатай.

Осол гэдэг нь:

1. Хүмүүсийн амь нас ба эрүүл мэндэд аюул учруулсан ба барилга байгууламж, тоног төхөөрөмж ба тээврийн хэрэгсэл эвдэж гэмтээсэн ба сүйтгэсэн, үйлдвэрлэлийн болон тээврийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, тэрчлэн хүрээлэн буй байгаль орчинд хохирол учруулсан техникийн шинжтэй аюултай учрал

2. Далайн эрх зүйд усан хөлөг онгоц, ачаа тээшинд учирсан хохирол

Ахуйн осол (англ. Off-the-job-injury; ор. бытовая травма)- ахуйн шинжтэй золгүй тохиолдлын улмаас эрүүл мэнд гэмтэх. (үз. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль).

ангилна. Харин дотоод шалтгаан буюу этиологийн дотоод хүчин зүйлд бие мах бодийн өөрийн дотоод шинж төлөв болох удамших шинж, биеийн галбир төрх, нас, хүйс, урвалж чанарын өөрчлөлт хувирал зэрэг хамаарна. Тэдгээрийн мөн чанар нь өөрчлөгдөж өвчин үүсгэж болно.

¹⁷ Ц.Цэцэгмаа, Б.Оюунбат-Эмгэг үйл судлал, 2004 он, 19-20 дахь тал

¹⁸ Мөн тэнд, 20 дахь тал.

Нийтлэг осол (англ. General average; ор. общая авария)- байгалийн онцгой аюул, давагдашгүй хүчин зүйлийн улмаас хөлөг онгоц, түүний ачаанд учирсан аюул

Томоохон осол (англ. Bad (serious) accident; ор. крупная авария)- МУ-д үйлдвэр, байгууламж, зам тээврийн хэрэгсэлд эвдрэл гарч, сүйрэлд орох, технологийн горим зөрчигдсөнөөс хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж, олон хүний амь нас, эрүүл мэнд хохирч, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирч аврах ажил гүйцэтгэх шаардлагатай нөхцөл байдал

Үйлдвэрлэлийн осол (англ. Production accident; ор. авария на производстве)- Даатгалын эрх зүйд даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөх. (үз. “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль). Түүнчлэн хурц хордлогыг Ү.о-той адилтган үзэх бөгөөд энэ нь даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордсоныг ойлгоно¹⁹.

Үг зүйн талаас нь авч үзвэл, “гэнэт” болон “осол” гэсэн үгнээс бүрдэх энэ ойлголтын агуулгыг монгол хэлний их тайлбар толиос дэлгэрүүлбэл:

Үг	Утга ²⁰
Гэнэт	Санамсаргүй атал хоромхонд болох
Гэнэтхэн	Гэв гэнэт, огт санамсаргүй байхад
Гэнэтийн аюул	Гэнэтийн осол
Гэнэт тохиолдох	Санамсаргүй тохиолдох
Гэнэтийн үзэгдэл	Байгалийн ер бусын үзэгдэл
Осол	Анхаарал болгоомжгүйгээс болж гарсан алдаа, эндэл
Осол болох	Алдаа, эндэл гарах

Үүнээс үзвэл, **гэнэтийн осол гэдгийг “тухайн этгээдийн нөлөөллөөс бус гаднын аливаа нөлөөллөөс гэмтэл, хохирол учрах, эрүүл мэндийн хэвийн байдал алдагдах явдал”** хэмээн тодорхойлж болохоор байна.

Энэ талаар СЗХ-оос гаргасан “Гэнэтийн ослын даатгалын андрайтингийн гарын авлага-2014”-т **“гэнэтийн осол” гэж гэрээний хугацаанд өвчний бус шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэсэн, даатгуулагчийн хүсэл эрмэлзлэлээс гадуур гэнэт богино хугацаанд бий болсон, урьдчилан харах боломжгүй, гаднын хүчин зүйлийн тааламжгүй нөлөөллийг хэлнэ²¹** хэмээн тодорхойлсон.

Түүнчлэн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын зарим компанийн даатгалын төрлийн нэг болох “гэнэтийн ослын даатгал”-д ямар үзэгдэл хамаарах, ямар эрсдэлийг хамгаалахаар мэдээлээснийг танилцуулахад:

Даатгалын компанийн нэр	Тодорхойлолт, хамрах хүрээ
Бодь даатгал	<i>Хүмүүс бидний санамсар болгоомжгүй үйлдэл, гэнэтийн аюул ослоос үүдэн учрах хохирлоос энэхүү даатгал хамгаална. Гэнэтийн осол гэж юу вэ?</i>

¹⁹ С.Нарангэрэл-Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг, 2015 он, 330 дахь тал.

²⁰ <https://mongoltoli.mn/dictionary/detail/28013> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

²¹ http://www.frc.mn/resource/frc/uploads/news/files/frc_imd_15_gariin%20avлага_geneteiin%20osliin%20d_aatgaliin%20gariin%20avлага.pdf, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

	<ul style="list-style-type: none"> • Халтирч унах, унаж бэртэх, элдэв зүйлд хавчуулагдах, гар хөлөө гэмтээх, түлэгдэх, элдэв хорт зүйл, хорт хий, эмийн зүйлээс хордох, угаартах, дээвэр тагтан дээрээс юм унах, зам тээврийн осолд өртөх гэх мэт; • Гал түймэрт өртөх, үер усанд автах, наранд цохиулах, элдэв хорт ургамалд хордох гэх мэт; • Морь малаас унах, чирэгдэх, малд өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, мал маллагаа, агнуурын болон бусад үед араатан амьтан, нохойд хазуулах, уруулах гэх мэт; • Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлого гэх зэргээр ажил мэргэжлийн онцлогоос хамааран гарах хохирол; • Машин, галт тэрэг, онгоцоор болон усан онгоцоор зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, шүргэлцэх, шарвах, унах, живэх зэргээс үүдэн бэртэж гэмтэх, улмаар амь насаа алдах; • Бусдад зодуулах, хорлогдох, буу хутга мäs бүхий этгээдийн дайралтад өртөх зэргээр гэнэтийн таагүй үйлтэй учрах.
<p>Ард даатгал</p>	<p><i>Ард Даатгал компанийн санал болгож буй Гэнэтийн ослын даатгал нь таныг бүх төрлийн гэнэтийн ослын улмаас бэртэж, гэмтсэн тохиолдолд эмчилгээний зардлыг нь нөхөн төлснөөр танд санхүүгийн бодит тусламж болох даатгал юм.</i></p> <p>Бид таныг ямар эрсдэлүүдээс даатгах вэ?</p> <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэл техникийн: Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед болон цахилгаан хүчдэл, дэлбэрэлт, шаталт зэргийн нөлөөгөөр учирсан осол, химийн бодист хордох, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс гарч болох осол гэх мэт эрсдэл. • Техниктэй харьцах үеийн: Унадаг дугуй, мотоцикл, автомашин зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, унах, живэх гэх мэт эрсдэл. • Байгалийн: Газар хөдлөлт, цасан болон шороон шуурга, хүчит салхи, үер, хөрсний нуралт, цөмрөлт, аянга, аадар бороо, мөндөр, ой хээрийн түймэр, усанд живэх, шавар намагт шигдэх гэх мэт эрсдэл. • Ахуйн: Унаж бэртэх, халтирах, зам тээврийн аюул осолд өртөх, элдэв юманд цохиулах, хавчуулах, түлэгдэх, хорт хийнд хордох гэх мэт эрсдэл. • Гаднын нөлөөллийн: Бусдын гэмт үйлдлийн улмаас сум, хутга мäsэнд өртөх, хорлогдох, зодуулах, цохиулах зэргээр гэмтэх гэх мэт эрсдэл.
<p>Хас банк</p>	<p><i>Иргэдийн гэнэтийн ослын даатгал: Ажлын цагаар, ажлын байран дээрээ ажил үүргээ гүйцэтгэж байх үед эсхүл Монгол улсын нутаг дэвсгэрийн хаана ч, дурын үед даатгуулагчид бүх төрлийн гэнэтийн осол тохиолдсоноос хөдөлмөрийн чадвараа түр алдах, хэсэгчлэн алдах, бүрмөсөн бүрэн алдах, нас барах тохиолдлуудад даатгуулагчид болон түүний ар гэрийнхэнд нөхөн төлбөр олгох зорилготой даатгал юм.</i></p> <p>Даатгах боломжит эрсдэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Бүх төрлийн гэнэтийн осол түүнээс учирч болох үр дагавар: • Хөдөлмөрийн чадвар түр болон бүрэн алдалт; • Тахир дутуугийн зэрэглэлд тогтоох; • Нас барах.

Ихэнх даатгалын компанийн цахим хуудаст “нөхөн төлбөр олгохгүй нөхцөл”-ийг тоочин жагсаасан байх ба нийтлэг байдлаар:

- Даатгуулагч нь даатгалд хамрагдахаас өмнө учирсан ослын улмаас олсон гэмтлийн урхаг, хор нөлөөг эдгэрүүлэх, сэргийлэх зорилгоор дахин эмчилгээ хийлгэж эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн бол,
- Даатгуулагчийн ажил мэргэжлээс шалтгаалах өвчин болон удаан хугацааны туршид үүссэн нуруу нугасны гэмтэл,

- Ердийн болон халдварт өвчний улмаас хэвтэж эмчлүүлсэн тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон болон рашаан сувиллын амралтын газар сувилуулж, эмчлүүлсэн бол,
- Бүх төрлийн өвчлөлөөс шалтгаалсан эмчилгээний аливаа зардал, хохирол учирсан тохиолдолд²² нөхөн төлбөр олгохгүй байхаар зохицуулсан нийтлэг талтай байна.

Иймээс гэнэтийн ослыг өвчин, тэр дундаа ердийн өвчнөөс ялгахын тулд өвчний тодорхойлолтын талаар судлах шаардлага зайлшгүй урган гарч байна. **Өвчин гэдгийг монгол хэлний тайлбар тольд “бие махбодын хэвийн үйл ажиллагаа алдагдаж хямрах эрүүл биш байдал, үзэгдэл” гэсэн бол эрх зүйн нэвтэрхий тольд “анагаах ухаанд тодорхой шалтгааны нөлөөллөөр үүсэж, тодорхой эмгэг – жамаар хөгжиж, өвөрмөц шинж тэмдгийн нийлбэр цогцоор илрэх эрүүл мэндийн хэвийн бус байдал, хүрээлэн буй орчинтой харилцан уялдаа холбоотойгоор хөдөлмөрийн чадвар түр буюу байнга буурсан эсхүл алдагдсан хүний бие организмын хэвийн үйл ажиллагаа зөрчигдөх; эрх зүйд өвчин нь аливаа хууль зүйн харилцаа үүсэх ба эрх зүйн холбогдох үр дагавар буй болгох үндэслэл буюу нөхцөл”** гэж тодорхойлжээ.

Иймд **“гэнэтийн осол”** гэдэгт **“үргэлжилдэггүй, давтагддаггүй (нэг удаагийн) шинжтэй, урьдчилан таамаглах боломжгүй, гэнэт болсон үйл явдлыг ойлгоно”** гэж тодорхойлж болох ба “өвчин” болон “гэнэтийн осол”-ыг үүсгэгдэж буй хүчин зүйл, зарим тохиолдолд (тухайн этгээд өөрийн эрүүл мэндийн нөхцөл байдлын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх тохиолдол) урьдчилан таамаглах боломжтой эсэх гэсэн шинжээр нь ялгаж болох юм гэж үзлээ. Энэ талаар харьцуулсан судалгааны дараах хэсэгт тайлбарлав.

Зарим гадаад улсад, жишээ нь Швейцарын Холбооны Улсын Нийгмийн Даатгалын тухай хууль (Social Insurance Law (GPSL))-ийн үзэл баримтлалд “өвчин”, “осол” зэрэг ойлголтуудыг ялгамжтай байлгахаар зааг ялгааг гаргахыг хичээсэн. Ийнхүү тодорхойлохдоо “осол” гэдэг нь “гардны онцгой хүчин зүйл хүний биед гэнэтийн, санамсаргүй байдлаар хор хөнөөл учруулж, улмаар бие махбод, сэтгэл санааны болон сэтгэл зүйн эрүүл мэнд, амь насаа алдахад хүргэдэг” гэж тодорхойлсон бол “өвчин” гэдэгт “ослоос үл хамаарах бие махбодын, сэтгэл санааны болон сэтгэл зүйн эрүүл мэндийн аливаа гэмтэл, эмчилгээ, үзлэг шаардлагатай байдал, хөдөлмөрийн чадвар алдалт” гэж ерөнхий байдлаар тодорхойлжээ. Энэхүү тодорхойлолтыг хувийн даатгалын компаниуд буюу энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүд өөр өөр байдлаар мөн тайлбарладаг хэрэглэдэг²³.

Түүнчлэн дээрх 2 ойлголтыг тайлбарлан хэрэглэхэд хүндрэлтэй зарим тохиолдлыг ялгахыг оролдсон ба үүнд:

²² Ард даатгал болон Хаан даатгалын албан ёсны цахим хуудаст хандан тус мэдээллийг олж авсан болно.

<https://arddaatgal.mn/%D0%B4%D0%B0%D0%B0%D1%82%D0%B3%D0%B0%D0%BB/%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B4%D0%B0%D0%B0%D1%82%D0%B3%D0%B0%D0%BB/%D1%8D%D1%80%D2%AF%D2%AF%D0%BB-%D0%BC%D1%8D%D0%BD%D0%B4-%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%BE%D1%81%D0%BB%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B4%D0%B0%D0%B0%D1%82%D0%B3%D0%B0%D0%BB/%D0%B8%D1%80%D0%B3%D1%8D%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%B3%D1%8D%D0%BD%D1%8D%D1%82%D0%B8%D0%B9%D0%BD-%D0%BE%D1%81%D0%BB%D1%8B%D0%BD-%D0%B4%D0%B0%D0%B0%D1%82%D0%B3%D0%B0%D0%BB/> <https://khaandaatgal.mn/p/37> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

²³ https://www.zurich.ch/en/services/knowledge/corporate/accident-or-illness#CE6B63_as (Сүүлд үзсэн: 2023.01.04).

- **Зөгийг хатгуулах - осол эсвэл өвчин үү?:** Хуульд заасан нэр томъёоны тодорхойлолтын дагуу осол гэдэг нэр томъёогоор гаднын онцгой хүчин зүйлийн хүний биед гэнэтийн, санамсаргүй хохирол учруулах нөлөөллийг хэлэх ба зөгийг хатгуулахыг осолд тооцдог. Үүнээс үүдэн гарч болзошгүй халдварыг ослын үр дагавар гэж үзэж болох тул ослын даатгалд хамрагдана.
- **Inguinal ивэрхий (Inguinal hernia) - осол эсвэл өвчин үү?:** Хуулийн заалтын ойлголтоор авч үзвэл энэ нь /шамбарам/ өвчин юм. Гэдэсний ивэрхий нь ихэвчлэн холбогч эдийн төрөлхийн сулрал эсвэл таргалалт, хэвлийн хөндийн даралт ихсэх зэргээс үүдэлтэй хэвлийн хананд ивэрхий үүсдэг. Жирэмслэлт нь гэдэсний ивэрхийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Гэдэсний ивэрхийг ихэвчлэн өвчин гэж үздэг бөгөөд *зөвхөн ховор онцгой тохиолдолд ослын үр дагавар юм.*
- **Тоглолтод оролцсоны дараах сонголын бэрхшээл - осол эсвэл өвчин үү?:** Ханна концерт үзэж байна. Гэртээ буцаж ирэхдээ тэр чихэнд нь ядаргаатай дуугарах чимээ гарч байгааг анзаарсан бөгөөд энэ нь маргааш нь үргэлжилдэг. Эмч чихний шуугианыг оношлоод гэнэтийн байдал байхгүй тул ослын тодорхойлолт энд биелэхгүй байна. Тиймээс энэ нь осол биш, харин өвчин юм. Ханна тоглолтод зочилсон зарим зочид зөвшөөрөлгүй салют бууддаг. Эдгээр салютуудын нэг нь Ханнагийн хажууд хүчтэй дэлбэрч байна. Эмч нь акустик гэмтэл гэж оношлогддог. Ослын тодорхойлолт энд биелдэг (гэнэтийн, санамсаргүй, онцгой гаднын хүчин зүйл, хохирол учруулах нөлөө) ийм учраас осол гэж тооцогддог²⁴.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхээр “гэнэтийн осол”, “осол”, “өвчин”-ий тодорхойлолтыг хэрхэн тодорхойлдог талаар “National life буюу “Нейшнл Лайф даатгал” ХХК-аас холбогдох мэдээллийг авах үүднээс тус даатгалын Э.Тэгштер гэх ахлах менежертэй биечлэн уулзаж, ярилцлага хийлээ. Ярилцлагын үр дүнг тоймлон авч үзвэл:

- Тус даатгалын компани нь ХБНГУ-ын *Munich Re* олон улсын даатгалын компанид давхар даатгагддаг бөгөөд урт хугацааны даатгалаар мэргэшин ажилладаг. Улмаар хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдвол түүнээс үүсэх санхүүгийн хүндрэлийг даван туулах, урт хугацаанд даатгалын хамгаалалттайгаар мөнгөн хуримтлал үүсгэдэг байгууллага.
- “Амьдралын даатгал” ХК нь олон улсын стандарт, хэм хэмжээнд нийцүүлэн өөрсдийн үйлчилгээ, бүтээгдэхүүнийг нэвтрүүлдэг ба даатгалын эрх зүйн харилцаанд холбогдох нэр томъёог боловсруулан тодорхойлохоор судалгаа хийн ажилладаг.

Тус компаниас судалгаа хийн дараах ойлголтын нэр томъёоны тодорхойлолтыг боловсруулсныг үзүүлбэл:

- **“Гэнэтийн осол”** гэж даатгалын гэрээний хугацаанд өвчний бус шалтгаанаар хүний бие организмын дотоод гадаад үүрэг, функц алдагдах, эд эрхтэнд гэмтэл учирч хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэсэн, Даатгуулагчийн хүсэл эрмэлзлээс гадуур гэнэт богино хугацаанд бий болсон, урьдчилан харах боломжгүй гаднын хүчин зүйлийн тааламжгүй нөлөөллийг;
- **“Өвчин”** гэж гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр хүний биеийн эд эс, эрхтний систем нь бүтэц, үйл ажиллагааны хувьд өөрчлөгдөн бие махбодын хэвийн үйл ажиллагаа алдагдахыг ойлгоно хэмээн тодорхойлжээ.

²⁴ Мөн тэнд. Эшлэл 23.

Хоёр. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2.1. ИБУИНХУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт

ИБУИНХУ-ын даатгалын эрх зүйн салбарыг хэд хэдэн гол эх сурвалжуудаар зохицуулдгийг доорх байдлаар дурдвал:

- **Хэрэглэгчийн даатгалын хууль /Consumer Insurance (Disclosure and Representations) Act, 2012/-** ИБУИНХУ-д даатгалын гэрээг хэрэглэгчийн болон хэрэглэгчийн бус гэж хоёр хувааж ялгамжтай зохицуулдаг. Энэхүү хуулиар хувь хүн болон даатгалын үйлчилгээ үзүүлэгчийн хооронд байгуулсан /худалдаа, бизнес болон мэргэжлийн зорилгоос бусад зорилгоор/ “хэрэглэгчийн даатгалын гэрээ”-тэй²⁵ холбоотой харилцааг зохицуулдаг.
- **Даатгалын хууль /Insurance Act, 2015/-** Харин тус хуулиар голчлон “хэрэглэгчийн бус даатгалын гэрээ”²⁶ буюу худалдаа, бизнес болон мэргэжлийн үйл ажиллагааны эрсдэлийг даатгуулах зорилгоор байгуулсан гэрээтэй холбоотой харилцааг зохицуулах ба зарим зохицуулалтууд нь хэрэглэгчийн даатгалын гэрээнд нэгэн адил хамаарч үйлчилдэг байна. Энэхүү хуулийг 1906 оны “Далайн тээврийн даатгалын хууль”-аас хойш Их Британийн даатгалын эрх зүйн салбарт хамгийн том шинэчлэлийг бий болгосон хууль гэж үздэг.
- **Амь насны даатгалын хууль /Life Assurance Act, 1774/-** Энэ хуулиар амь насны даатгал сайн дурын байх, даатгалд заавал даатгуулагчийн нэрийг тусгах зэрэг суурь зарчмуудыг хуульчилсан.
- **Далайн тээврийн даатгалын хууль /Marine Insurance Act, 1906/-** Энэхүү хууль нь Их Британийн орчин үеийн даатгалын эрх зүйн суурийг тавьсан эрх зүйн эх сурвалжид тооцогддог бөгөөд “good faith” буюу “шударга үнэний зарчим”-ыг хуульчлан тогтоожээ.
- **Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хууль /Financial Services and Markets Act, 2000/-** Тус хуулиар даатгалын үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, түүний эрх хэмжээг зохицуулсан.

Дээрх ИБУИНХУ-ын холбооны түвшинд (нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд) мөрдөгдөх даатгалын эрх зүйн эх сурвалжуудад өвчин гэдэгт чухам ямар эмгэг нөхцөлийг хамааруулж үзэх талаарх албан ёсны тодорхойлолтыг хуульчлаагүй байна. Харин даатгалын гэрээний төрлүүд буюу ямар тохиолдолд аль төрлийн даатгалд даатгуулахыг нарийвчлан ялгаж зохицуулжээ.

Тус улсад даатгалын гэрээг ерөнхий 2 төрөлд ангилдаг. Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хуулийг даган гарсан тушаалаар²⁷ даатгалын үйлчилгээ үзүүлэгчээс байгуулж болох даатгалын гэрээний төрлийг “**ердийн**” /general/ болон “**урт хугацааны**” /long-terms/ хэмээн хоёр ангилсан. Ердийн даатгалд ослын улмаас гэмтэх, нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдах, тээврийн хэрэгслийн, агаарын тээврийн, гал болон байгалийн гамшгийн, өмчийн, зээлийн зэрэг болон бусад даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд урьдчилан тохирсон нөхөн төлбөрийг олгох зориулалт бүхий 18 төрлийн

²⁵ Consumer insurance contract. /орч. англ/

²⁶ Non-consumer insurance contract /орч. англ/

²⁷ Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хуулиар зохицуулах үйл ажиллагааны тухай тушаал, (The Financial Service and Markets Act 2000 (Regulated activities) order 2001) <https://www.legislation.gov.uk/uksi/2001/544/contents/made>. (Сүүлд үзсэн: 2023.01.03).

даатгалын гэрээг хамруулдаг.²⁸ Харин урт хугацааны даатгалын гэрээнд амь насны даатгал, хүнд өвчний, гэрлэлтийн, тэтгэврийн сангийн менежмент зэрэг болон бусад урт хугацааны туршид даатгалын нөхөн төлбөр олгох даатгалын гэрээнүүд хамаарна.²⁹

Эрүүл мэнд болон амь насны даатгалын зохицуулалтын тухайд дээрх эх сурвалжаар ердийн болон урт хугацаанд үргэлжлэх даатгалын тохиолдлыг ялгамжтай тодорхойлжээ. Урт хугацааны эрүүл мэндийн даатгал */permanent health insurance/*-ийн ердийн эрүүл мэндийн даатгалаас */sickness insurance/* ялгарах шинж нь даатгуулагч осол болон өвчний улмаас 5 болон түүнээс дээш жил, тэтгэвэрт гарах хүртэл, эсхүл тодорхой хугацаагүйгээр буюу урт хугацааны туршид хөдөлмөрийн чадвараа алдах эрсдэлийн тохиолдолд байгуулдаг. Ердийн эрүүл мэндийн даатгал нь дээрхээс бусад тохиолдлуудыг хамарна.³⁰ **Амь насны даатгалын тухайд ердийн даатгалын гэрээнээс урт хугацааны амь насны даатгалын гэрээ */life and annuity insurance/*-ний ялгарах онцлог нь тодорхой хугацаанд тогтсон мөнгөн дүнг байнга олгох тохиолдолд байгуулна.**³¹

Практикт даатгалын үйлчилгээ үзүүлэгч компаниуд дээрх ангилал, зохицуулалтын хүрээнд хоорондоо харилцан ялгаатай эрүүл мэнд, амь насны даатгалын үйлчилгээний төрлүүдийг боловсруулан зах зээлд нийлүүлж байна. Тухайлбал, амь насны даатгал, ослын даатгал, хүнд өвчний даатгал, моргажийн буюу ипотекийн даатгал гэх мэт.

Их Британи улсын зах зээлд нийлүүлэгдэж буй амь насны даатгал */life insurance/* нь дотроо өвчний улмаас нас барсан тохиолдолд, ослын улмаас нас барсан тохиолдолд, моргажийн даатгал гэх мэт хэд хэдэн дэд төрлүүдтэй. Даатгуулагч өвчний улмаас нас барснаар учирч болох санхүүгийн хүндрэл, эрсдэлээс сэргийлэх зорилгоор тодорхой хугацааны болон насан туршийн даатгал хийлгэх боломжтой. Харин ослын улмаас нас барсан тохиолдолд зөвхөн ослын даатгалаас нөхөн төлбөр гаргуулах боломжтой */personal accident insurance/*. Ослын даатгал нь амь насны даатгалын тусгай төрөл бөгөөд тус даатгалын тохиолдолд нас барсан шалтгаан нь өвчин бус зөвхөн ослоос шалтгаалсан байхыг шаардана.³²

Моргажийн буюу ипотекийн даатгал нь орон сууцны моргажийн зээлтэй даатгуулагч моргажийн зээлийн хугацаанд нас барсан тохиолдолд үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор зээлийн төлбөр төлөх хугацаанд хамрагдаж болох сайн дурын даатгал юм. Моргажийн даатгал нь орлогын болон амь насны гэсэн хоёр төрөлтэй бөгөөд заавал даатгуулах шинжгүй.³³

Хүнд өвчний даатгал буюу “*critical illness insurance*” нь даатгуулагч хүнд өвчин туссаны улмаас санхүүгийн хүндрэлд орсон тохиолдолд даатгагчаас нөхөн төлбөр олгоход чиглэсэн даатгалын гэрээний тусгай төрөл юм. Энэ нь амь насны даатгалаас ялгаатай буюу зөвхөн хүнд өвчний улмаас эрүүл мэндийн хувьд хүнд нөхцөлд орсноор бий болох санхүүгийн хүндрэлээс сэргийлэх зорилготой.

²⁸ Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хуулиар зохицуулах үйл ажиллагааны тухай тушаал, (The Financial Service and Markets Act 2000 (Regulated activities) order 2001), Хавсралт 1-ийн Нэгдүгээр хэсэг, <https://www.legislation.gov.uk/ukxi/2001/544/contents/made> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

²⁹ Мөн тэнд, Хавсралт 1-ийн Хоёрдугаар хэсэг

³⁰ Мөн тэнд, Хавсралт 1-ийн 2.4.

³¹ Мөн тэнд, Хавсралт 1-ийн 2.1.

³² <https://www.investopedia.com/terms/a/accidental-death-benefit.asp> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

³³ <https://www.thetimes.co.uk/money-mentor/article/mortgage-life-insurance/> болон <https://www.forbes.com/advisor/life-insurance/mortgage-life-insurance/> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

Хүнд өвчин гэдэгт хамруулах өвчний хүрээг үйлчилгээ үзүүлэгч компани тус бүрд харилцан адилгүй байх боловч дараах өвчнүүд нийтлэг хамаардаг байна. Үүнд:³⁴

- Цус харвалт;
- Зүрхний шигдээс;
- Паркинсоны өвчин;
- Алзгеймерийн өвчин;
- Хорт хавдрууд;
- Эрхтэн шилжүүлэн суулгах гэх мэт.

Дээрхээс үзэхэд ИБУИНХУ-д эрүүл мэнд болон амь насны даатгалын хувьд хоорондоо нарийн ялгаатай төрлүүд хэрэглэгддэг бөгөөд даатгуулагч ямар төрлийн эрсдэлийн даатгалд даатгуулснаас хамааран тухайн тохиолдолд нөхөн төлбөрийг гаргуулан авах боломжтой байна.

Даатгалын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хуульд зааснаар Эрсдэлийн зохицуулалтын хороо */Prudential Regulation Authority/* хариуцах³⁵ ба даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллага ердийн болон урт хугацааны даатгал үзүүлэх **зөвшөөрлийг тусад нь авдаг**.³⁶

Амь насны даатгалын үйлчилгээ үзүүлэгч компанид тавигдах шаардлагыг “Амь насны даатгал гаргагч компанийн тухай хууль” */The Life Assurance Companies Act, 1870/*-аар тусад нь зохицуулдаг байна.

ИБУИНХУ-д даатгалын гэрээтэй холбоотой ямарваа маргаан гарахад **“good faith/ utmost good faith”**³⁷ буюу “шударга үнэний зарчим” чухал ач холбогдолтой. 1906 онд батлагдсан “Далайн тээврийн даатгалын хууль”-ийн 17 дугаар зүйлд “даатгалын гэрээ /далайн тээврийн даатгалын гэрээ/ нь шударга үнэний зарчимд үндэслэнэ”³⁸ гэж зааснаар анхны эрх зүйн үндэслэл бүрэлдсэн байдаг. Тус зарчим нь даатгалын эрх зүйд нэвтэрсэн түүхэн үүслийн хувьд жишгийн эрх зүйгээс үүдэлтэй буюу 1766 онд Их Британийн шүүгч Виллиам Мэнсфeyлд */William Mansfield/*-ийн шийдвэрлэсэн нэгэн даатгалын гэрээний маргаанаас эхлэлтэй.

Carter v Boehm /1766/: Баруун Индонезын Суматра арал дээр орших Марлбоур цэргийн хамгаалалтын хэрмийг захирагч Картер */Mr. Carter/* гаднын ямар нэгэн довтолгоонд өртөж нурах эрсдэлээс сэргийлэх зорилгоор хэрмийг даатгалын компанид даатгуулжээ. Даатгалын хугацаанд Францын довтолгоо болж хамгаалалтын хэрэм нурсан бөгөөд даатгагчаас даатгуулагч нь хэрмийн бат бөх чанарын талаар болон Францийн довтолгоо өрнөх эрсдэлийн талаарх мэдээллийг анхнаас нь өгөөгүй учир нөхөн төлбөр төлөхөөс татгалзаж шүүхэд хандсан байна. Шүүгч Мэнсфeyлд тус шийдвэрийн дүгнэлтдээ:

“...Даатгалын гэрээ нь таамаглалд үндэслэдэг гэрээ юм. Боломжит эрсдэлийг тооцоолоход шаардагдах онцгой баримтууд нь даатгуулагчийн мэдлийн хүрээнд

³⁴ <https://www.unbiased.co.uk/discover/insurance/critical-illness-insurance/what-is-critical-illness-insurance-and-do-i-need-it> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

³⁵ Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хууль, (Financial Service and Market Act 2000), 2с ба 55с зүйл. <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/8/contents>, (Сүүлд үзсэн: 2023.01.03).

³⁶ [https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-501-2031?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true#co_anchor_a798742](https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-501-2031?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a798742) (Сүүлд үзсэн: 2023.01.03).

³⁷ Даатгалын эрх зүйн салбарт энэхүү хууль зүйн нэр томъёог “харилцан итгэлцлийн зарчим” гэж орчуулж мөн болох юм гэж үзсэн.

³⁸ Далайн тээврийн даатгалын тухай хууль, (Marine Insurance Act 1906), 17 зүйл. <https://www.legislation.gov.uk/ukpga/Edw7/6/41/contents> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

голчлон хадгалагддаг. Даатгагч нь даатгуулагчийн өгсөн мэдээлэлд итгэж, эрсдэлд нөлөөлөхүйц нөхцөл байдал байхгүй гэж түүнийг төөрөгдүүлэх байдлаар эрсдэлийг үнэлүүлээгүй, ямар нэг нөхцөл байдлын талаар нуун дарагдуулаагүй гэсэн итгэлд үндэслэн үйлчилгээ үзүүлдэг. Тийм нөхцөл байдлуудыг **мэдээлэхгүй байх нь өөрөө мэхлэлт учир даатгал нь хүчингүй. Нуусан явдал нь хууран мэхлэх зорилгогүй, санамсаргүй алдаанд үндэслэсэн байсан ч даатгуулагчийг мэхлэгдсэн гэж, гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.** Учир нь нэгэнт учирсан эрсдэл нь гэрээ байгуулах үед мэдэгдэж, хэрэгжихээр таамаглаж байсан эрсдэлээс өөр юм...**Шударга үнэний зарчим нь гэрээний талуудыг өөрт ашигтай хэлэлцээр хийхийн тулд өөрийн мэдэж буй мэдээллийг нуухыг хориглоно...**" гэжээ.³⁹

Шударга үнэний зарчмын дагуу гэрээний талууд даатгуулах гэж буй эрсдэлд хамааралтай бүхий л баримтыг үнэнч шударгаар ил гаргах үүрэгтэй.⁴⁰ Их Британийн Хэрэглэгчийн даатгалын хуульд зааснаар даатгуулагч нь даатгагчид алдаатай мэдээлэл өгөхөөс сэргийлж няхуур анхааралтай байх үүрэгтэй.⁴¹ Тус үүргээ санаатай болон болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн бол даатгуулагч хариуцлага хүлээнэ.⁴²

Даатгагч нь даатгалын гэрээг байгуулахаас өмнө эсхүл гэрээнд өөрчлөлт оруулахаас өмнө даатгуулагчийн гаргасан үүргийн зөрчлөөс дараах тохиолдолд зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй:

- Даатгуулагч хуульд заасан үүргээ зөрчсөн;
- Тухайн алдаатай мэдээлэл байгаагүй бол даатгагч тухайн гэрээг байгуулахгүй байсан эсхүл өөр нөхцөлөөр байгуулахаар байсан бол.⁴³

Хэрэв даатгуулагч санаатайгаар үүргээ зөрчсөн бол даатгагч гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулж нөхөн төлбөр төлөхөөс татгалзах, даатгалын хураамжийг буцаан төлөхөөс татгалзах эрхтэй. Харин даатгуулагч болгоомжгүйн улмаас үүргээ зөрчсөн тохиолдолд даатгагч тухайн гэрээг анхнаасаа байгуулахгүй байсан гэж үзвэл гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулж нөхөн төлбөр төлөхөөс татгалзах эрхтэй ч даатгалын хураамжийг даатгуулагчид буцааж өгөх ёстой. Хэрэв өөрчилсөн нөхцөлөөр даатгалын гэрээг байгуулах боломжтой байсан бол даатгагчийн зөвшөөрснөөр гэрээг өөрчилсөн нөхцөлөөр байгуулсанд тооцно.⁴⁴

Мөн Хэрэглэгчийн даатгалын тухай хуульд тухайн нэг даатгалын маргааны онцлог, нөхцөл байдлаас хамааруулан даатгуулагчийг үүргээ зөрчсөн гэж үзэхгүй байж болох тохиолдлуудыг хуульчилжээ. Жишээлбэл:

- Маргаж буй даатгалын гэрээний төрөл болон зорилтот зах зээлээс хамааруулж;
- Даатгагчаас гаргасан ач холбогдол бүхий нийтэд нээлттэй, тайлбар материалуудаас хамааруулж;

³⁹ Dina Esmail M Abuzaid, Reform of the Doctrine of Utmost Good Faith: A Company study between the UK and Suadi Arabia (thesis for doctoral degree), UK, 2018, p.56 <https://dspace.stir.ac.uk/bitstream/1893/28038/1/PhD%20Thesis%20-%20Dina%20Abuzaid-%2010102018.pdf>. (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁴⁰ Мөн тэнд, Эшлэл 39. 58 дахь тал.

⁴¹ Хэрэглэгчийн даатгалын хууль, (Consumer Insurance Act 2012), 2.2 зүйл. <https://www.legislation.gov.uk/ukpga/2012/6/schedule/2>, (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁴² Мөн тэнд, 5.1.

⁴³ Мөн тэнд, 4.1.

⁴⁴ Мөн тэнд, Хавсралт 1.

- Даатгагчаас даатгуулагчид тавьсан асуултууд нь хэр тодорхой, ойлгомжтой байснаас хамааруулж;
- Даатгалын гэрээг шинэчлэх үед даатгагчаас тавьсан асуултад хариулахад даатгагч даатгуулагчтай ойлгомжтой байдлаар харилцаж байсан эсэх /эсхүл асуултад буруу хариулснаар үүсэх боломжит үр дагавруудын талаар даатгуулагчид тодорхой тайлбарласан эсэх/;
- Даатгалын үйлчилгээ үзүүлэгч ажилтан даатгуулагчид хэрхэн үйлчилсэн гэх мэт⁴⁵ нөхцөлүүдийг даатгуулагчийг алдаатай, дутуу мэдээлэл өгөхөөс сэргийлэх, няхуур хянамгай байх үүргээ зөрчсөн эсэхийг шийдвэрлэхэд анхаарч үзнэ.

Хэрэглэгчийн бус даатгалын тухайд 2015 оны Даатгалын хууль батлагдсанаар 1906 оноос хойших Их Британийн даатгалын эрх зүйн зохицуулалт дахь хамгийн том шинэчлэл хийгдсэн гэж үздэг.⁴⁶

Тус хууль батлагдахаас өмнө мэдээлэл өгөх үүрэг нь даатгагч, даатгуулагчдад тэгш бус хуваарилагддаг байсан төдийгүй даатгуулагч гэм буруугүй байсан ч хангалттай мэдээлэл өгөөгүйнхээ хариуцлагыг хүлээдэг байв. Шинэчлэгдсэн даатгалын хууль батлагдсанаар хэрэглэгчийн бус даатгалын гэрээнд шударга үнэний зарчмыг сахиулах хүрээнд зарим өөрчлөлт оржээ. Тухайлбал, **даатгуулагч даатгах гэж буй эрсдэлтэй холбоотой өөрийн мэдэж байгаа, мэдэх ёстой бүхий л нөхцөл байдлуудыг даатгагчид хэлэх ёстой ба “хянамгай даатгагч”-ийг цаашид шалган тодруулах асуудлуудыг тодорхойлоход хангалттай хэмжээнд л өөрийн мэдэх бүх мэдээллийг өгснөөр үүргээ биелүүлсэн гэж үзнэ.**⁴⁷

Ингэснээр мэдээллийг нягтлах үүрэг даатгагчид шилжих бөгөөд даатгуулагчаас цаашид мэдээллүүдийг нарийвчлан тодруулах нь даатгагчийн үүрэгт хамаарна. Хэрэв хуульд заасан мэдээллээр хангах үүргээ зөрчсөн гэж үзвэл даатгагч тухайн мэдээллийг анхнаас нь ил нээлттэйгээр мэдсэн бол гэрээг байгуулахгүй байсныг, мөн даатгуулагчийг санаатайгаар тус үүргээ зөрчсөнийг нотлох үүрэгтэй байхаар өөрчлөлт оруулжээ.⁴⁸

2.2. БНСУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт⁴⁹

БНСУ-д даатгалыг 3 төрөлд хуваан авч үздэг. (Даатгалын бизнесийн тухай хуулийн 2-р дугаар зүйл) Үүнд:

- 1. Амьдралын даатгал-** Даатгуулагчид эсэн мэнд үлдэхийн тулд эсвэл аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор нас барсан бол нөхөн төлбөр авах болон бусад нөхөн төлбөрийг төлөхөөр тохиролцож буй даатгал юм.
- 2. Амьдралын бус даатгал-** Даатгуулагчийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай гэрээ (гэрээгээр хүлээсэн үүрэг, хуулиар хүлээсэн үүрэг, үүргээ биелүүлээгүйгээс үүсэх аливаа хохирол орно), гэнэтийн нөхцөл байдлын үр дүнд бий болсон (с)-д заасан өвчин, гэмтэл, эмчилгээг эс тооцвол) аливаа эрсдэлийг багтана.
- 3. 3 төрлийн даатгал буюу давхардсан даатгал-** Даатгуулагчид аливаа өвчин, гэмтэл, түүнийг эмчлүүлсэн тохиолдолд нөхөн төлбөр авах зорилгоор аливаа

⁴⁵ Мөн тэнд, 3.2.

⁴⁶ Даатгалын маргааны эрх зүйн зохицуулалтын тойм /цахим нийтлэл/, 2022.11.29 <https://thelawreviews.co.uk/title/the-insurance-disputes-law-review/united-kingdom-england--wales> (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁴⁷ Даатгалын хууль (Insurance Act 2015), 3 зүйл цахим холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2015/4/contents/enacted>, (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁴⁸ Цахим эх сурвалж: <https://thelawreviews.co.uk/title/the-insurance-disputes-law-review/united-kingdom-england--wales>, (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁴⁹ 보험업법 2003, Insurance Business Act.

эрсдэлээс хамгаалах зорилгоор тогтоосон нөхөн төлбөр болон бусад тэтгэмжийг олгодог даатгал.

БНСУ-ын Даатгалын бизнесийн тухай хууль

4 дүгээр зүйл (Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл)

(1) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх гэж байгаа этгээд нь дараах дэд зүйлд заасан даатгалын бизнесийн төрлүүдийн дагуу Санхүүгийн үйлчилгээний хорооноос тусгай зөвшөөрөл авна.

1. Амьдралын даатгалын бизнесийн төрлүүд:
 - (а) Амьдралын даатгал;
 - (б) Тэтгэврийн даатгал (тэтгэвэрт гарсны дараах даатгал орно);
 - (в) Бусад даатгалын төрлийн үйл ажиллагаа.
2. Амьдралын бус даатгалын бизнесийн төрлүүд:
 - (а) Галын даатгал;
 - (б) Далайн даатгал (агаарын болон тээврийн даатгал орно);
 - (в) Автомашины даатгал;
 - (г) Баталгаат даатгал;
 - (д) Зарим давхар даатгал;
 - (е) Даатгалын бусад төрлийн үйл ажиллагаа.
3. 3 төрлийн даатгал буюу давхар даатгалын бизнесийн төрлүүд:
 - (а) Гэмтлийн даатгал;
 - (б) Өвчний даатгал;
 - (в) Сувилахуйн даатгал;
 - (г) Бусад төрлийн даатгалын үйл ажиллагаа.

Даатгалын залилангаас урьдчилан сэргийлэх тусгай ажиллагааны тухай хууль

4 дүгээр зүйл (Даатгалын залилангийн талаарх хүсэлт гаргах)

Даатгалын гэрээ⁵⁰ байгуулсан даатгуулагч, даатгалын нөхөн төлбөр авахаар хүлээгдэж буй этгээд болон бусад сонирхогч этгээдийг (цаашид "даатгал эзэмшигч гэх мэт" гэх) даатгалын залилангийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэх үндэслэл байгаа бол даатгалын нөхөн төлбөр төлсөн тохиолдолд даатгалын компани энэ тухайгаа Санхүүгийн үйлчилгээний комисст мэдээлж болно.

БНСУ-ын Мариланд даатгалын компани гарын авлагад⁵¹: Ихэнх тохиолдолд ипотекийн зээл олгогчид орон сууцанд байгаа санхүүгийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд орон сууцны өмчлөгчийн даатгалыг хамруулах бодлого баримталдаг, нэмэлтээр орон сууцны эзэмшигчийн хувиар даатгалд хамруулах шаардлагатай байдаг. Ипотекийн зээлээр авсан орон сууцаа заавал даатгуулдаг бөгөөд ипотекийн зээл авагч иргэн өөрийгөө даатгуулах бол Даатгалын бизнесийн үйл ажиллагааны даатгалын төрлөөс хамааран даатгуулдаг байна.

Мөн гэнэтийн ослын даатгал ойлголт гэсэн бие даасан ойлголт байхгүй бөгөөд ослын даатгал бүр гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх даатгалд хамаардаг байна. Жишээлбэл: Аливаа өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол өвчний даатгалд хамаарна.

Харин ажлын байранд болсон аливаа гэнэтийн ослыг "Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хууль"-аар зохицуулдаг. Тус хуульд нэр томъёог дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн осол гэдэг нь мэргэжилтэй холбоотой үүссэн аливаа гэмтэл, өвчин, хөгжлийн бэрхшээлтэй болох эсвэл нас барахыг ойлгоно. (Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйл)
- "Хөгжлийн бэрхшээл" гэдэг нь гэмтэл, өвчин нь эдгэрсэн боловч сэтгэцийн болон бие махбодын хохирлын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, эсвэл буурсан байдлыг. (Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйл)

⁵⁰ Аливаа даатгалын гэрээ хийхдээ тухайн хүн ямар нэгэн өвчин эмгэгтэй, эсвэл өр зээлтэй талаарх мэдээллийг бүрэн судалж мөн даатгуулагч үнэн зөвөөр гаргаж даатгалын гэрээний загварт бөглөж өгөх үүрэгтэй бөгөөд энэ шаардлагыг биелүүлээгүй бол даатгалын нөхөн төлбөр олгодоггүй байна. https://www.kbinsure.co.kr/images/claim_svc/reqdoc_genal.pdf. (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁵¹ <https://insurance.maryland.gov/%ED%95%9C%EA%B5%AD%EC%96%B4/Documents/ConsumerGuideHomeownersInsKorean.pdf>. (Сүүлд үзсэн: 2023.01.03).

- Хөдөлмөрийн чадвар буурах нь хөгжлийн бэрхшээлийн нэг хэлбэр бөгөөд хөдөлмөрийн чадвар алдсан хугацаанд нь хөгжлийн бэрхшээлд тооцдог байна.

2.3. Япон Улсын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт⁵²

Япон Улсын Даатгалын тухай хууль⁵³ 2008 оны 6-р сарын 6-нд батлагдаж, 2010 оны 4-р сард хүчин төгөлдөр болсон. Тус улсад даатгалыг 3 төрөлд ангилан үздэг.

(Даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйл)

1. **Амьдралын бус даатгал:** Тодорхой учирч болзошгүй аливаа хохирлыг даатгагч нөхөн төлөхөөр тохиролцсон даатгалын төрөл;
2. **Амьдралын даатгал:** Даатгагч нь тухайн хүний амьд үлдэхэд шаардлагатай болон нас барсантай холбогдуулан даатгалын тогтмол орлогын төлбөрийг хийхээр тохиролцсон даатгалын бодлого (осол, болон эрүүл мэндийн даатгалын ангилалд хамаарах даатгалыг тооцохгүй);
3. **Осол болон эрүүл мэндийн хамтын даатгал:** Амьдралын бус даатгалд хамаарахгүй даатгуулагчийн биед учирсан гэмтэл, өвчин зэрэг учирч болох аливаа хохирлыг нөхөн төлөхөөр тохиролцсон даатга (гэмтэл, өвчинд туссан хэмжээгээр нь учирсан хохирлоор хязгаарлагдах);

Даатгалын бизнесийн тухай хуульд⁵⁴:

II хэсэг Даатгалын компаниуд I бүлэг Ерөнхий заалтууд (Лицензүүд)

3 дугаар зүйл (1) Ерөнхий сайдаас зөвшөөрөл авалгүйгээр ямар ч хүн даатгалын үйл ажиллагаа эрхэлж болохгүй.

3 дугаар зүйл (2) Өмнөх догол мөрөнд заасан тусгай зөвшөөрөл нь амьдралын даатгалын үйл ажиллагааны лиценз, амьдралын бус даатгалын үйл ажиллагааны лиценз гэсэн хоёр төрлөөс бүрдэнэ.

3 дугаар зүйл (3) Нэг хүн амьдралын даатгалын бизнесийн лиценз болон амьдралын бус даатгалын бизнесийн лицензийг хоёрыг зэрэгцүүлэн авч болохгүй.

Даатгалын бизнесийн тухай хуулиар Япон улсад даатгал, давхар даатгалын үйл ажиллагааны хяналт, холбогдох журмуудыг тусгасан. Даатгалын бизнесийн тухай хуулийн дагуу Япон улсад үйл ажиллагаа явуулах даатгал, давхар даатгалын компаниуд нь Япон улсад салбараа байгуулж, үйл ажиллагаа явуулах **зөвшөөрөл авсан байхыг шаарддаг**.

Гэхдээ дор дурдсан даатгалын гэрээг зөвшөөрөлгүй гадаадын даатгагч байгуулж болдог. Үүнд:

- Давхар даатгал,
- Олон улсын ачаа тээвэр,
- Хилийн чанад дахь аяллын даатгал,
- Даатгуулагч нь FSA-аас зөвшөөрөл авсан тохиолдол.

Тус улсын Даатгалын тухай хуулиар даатгалын гэрээний хэм хэмжээг зохицуулсан.

Даатгалын гэрээнд тусгагдах ёстой үндсэн агуулга, даатгагчид мэдээлэл гаргаж өгөх үүрэг, гэрээний бүртгэл зэрэг асуудлыг нарийвчлан тусгаж өгсөн байна. Хуулиар даатгуулагч нь даатгагчид эрсдэлтэй холбоотой мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй байхаар заасан. Хуулийн дагуу даатгуулагчийн эрхийг хамгаалах зорилго бүхий заавал тусгах шаардлагатай заалт болон гэрээнд тусгах шаардлагатай нөхцөлүүдийн талаар дурдсан байдаг.

Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий заалтуудыг мөрдөхгүй байж болох гэрээнүүдийг тусгайлан зааж өгсөн байдаг бөгөөд үүнд:

- Усан тээврийн даатгал;

⁵² Seiichi Ochiai, Shinichi Takahashi and Ryoko Takeda, "Japan: the insurance concept in the Insurance Act and the Insurance Business Act", 2012.

⁵³ Insurance Act, 2008

⁵⁴ Insurance Business Act, 1995

- Агаарын хөлөг, агаарын ачааны даатгал;
- Цөмийн үйл ажиллагааны даатгал;
- Бизнесийн үйл ажиллагааны даатгал орно.

Даатгалын тохиолдол гарсан үед даатгуулагч нь даатгагчид шуурхай мэдэгдэх үүрэгтэй бөгөөд эс үйлдлээс шалтгаалсан нэмэгдэл хохирлыг нөхөн төлбөрөөс хасах, хоцрогдуулснаас шалтгаалсан зардлыг даатгуулагчаас гаргуулах эрхтэй болдог.

Гэрээг баталгаажуулахад даатгалын гэрчилгээг даатгуулагчид өгөх ёстой бөгөөд үүнд ерөнхий мэдээллийг тусгасан байхыг шаарддаг байна.⁵⁵ Түүнчлэн Япон Улсад ипотекийн зээл авч буй иргэд амьдралын даатгал хийлгэхийг шаарддаг байна.⁵⁶

2.4. Австралийн Холбооны Улсын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт

Даатгалын болон давхар даатгалын ойлголт: АХУ-ын 1973 оны Даатгалын тухай хууль болон 2002 оны Даатгалын журам нь ердийн даатгал болон андеррайтуудаас гаргасан даатгалын зөвшөөрлийн тухай болон давхар даатгалын талаар зохицуулдаг. Харин 1973 оны Даатгалын тухай хуулийн 3А хэсэг, ердийн даатгагч нь АХ-ны шүүхээс баталсан схемээс өөр бусад тохиолдолд гаргасан бодлогын дагуу даатгалтай холбогдох эрх, үүрэг хариуцлагыг АХУ-ын зохицуулалттай өөр даатгалын компанид шилжүүлэхийг хориглодог⁵⁷.

Даатгалын гэрээний тухай хууль 1984 (Insurance contracts act) болон 1995 оны даатгалын гэрээний журам (Life Insurance Regulations)-аар ердийн болон амьдралын даатгалын ихэнх гэрээг зохицуулдаг.

1995 оны Амьдралын даатгалын зохицуулалтууд нь даатгалын болон давхар даатгалын аль алиныг нь зохицуулдаг. Нэмж дурдахад, АХ-ны шүүх нь амьдралын даатгалын компанийн амьдралын даатгалын бизнесийг өөр амьдралын даатгалын компанид шилжүүлэх эсвэл түүнтэй нэгтгэхийг хүлээн зөвшөөрдөг байх ёстой.

2001 оны Корпорацын тухай хууль ба Корпорацын журам (The Corporation act and Corporation Regulations 2001)-ын 7-р бүлэгт ердийн болон амьдралын даатгалын бүтээгдэхүүний лиценз, ил тод байдал, үйл ажиллагааны шаардлагыг тодорхойлсон байдаг.

Австралийн Үнэт цаас, хөрөнгө оруулалтын хорооны 2001 оны хууль (Cth) (ASIC хууль) нь даатгагчдыг (санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд) төөрөгдүүлсэн, хууран мэхлэх, түүнчлэн ухамсаргүй үйлдэл хийхийг зарим талаар хориглодог;

АХУ-ын даатгалын салбар (түүнд хамаарах ойлголт, төрөл, ангилал)

АХУ-ын даатгал нь амь нас, эрүүл мэнд болон ердийн даатгал гэсэн гурван төрөлд хуваагддаг.

- Амь нас буюу амьдралын даатгал нь нас барах, тахир дутуу болох, гэмтэл бэртэл авах зэргээр гарах үр дагавруудыг хамардаг.
- Эрүүл мэндийн даатгал нь эмнэлгийн, туслах эмнэлгийн, болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх төлбөрийг олгодог.
- Ердийн даатгал нь амьдралын болон эрүүл мэндийн даатгалын алинд ч тусгагдаагүй бөгөөд үүнд, бүтээгдэхүүний хариуцлага, аялал жуулчлал,

⁵⁵ Даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа-2022, 29-30 дахь тал.

⁵⁶ <https://housekey.jp/set-up-life-insurance-for-mortgage-home-loan-japan/>, (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁵⁷ [The Insurance and Reinsurance Law Review - The Law Reviews](#), (Сүүлд үзсэн: 2023.01.03).

мэргэжлийн үйл ажиллагааны нөхөн төлбөр, өвчин, осол зэрэг асуудлуудыг хамардаг⁵⁸.

Өргөдөл гаргагчдын эрүүл мэндийн мэдээллийг цуглуулж, ашиглан даатгуулагчийн нас баралт болон өвчлөлийн эрсдэлийн үнэлгээг шаарддаг бөгөөд ийнхүү харилцан үнэлгээ өгдөг даатгалын бодлоготой холбоотойгоор **генетикийн мэдээлэл** хамгийн чухалд тооцогдох магадлалтай байдаг бөгөөд даатгалыг дараах байдлаар авч үздэг⁵⁹:

- Амьдралын хугацааны даатгал- Даатгуулагч нас барсан тохиолдолд тохиролцсоноор нэг удаагийн нөхөн төлбөрийг олгохоор заасан. Хөрөнгө оруулалт санхүүгийн үйлчилгээний нийгэмлэг (IFSA)-ийн мэдээлснээр АХУ-ын амьдралын хугацааны даатгалын нөхөн төлбөрийн дундаж түвшин 235'000 доллар байдаг.
- Орлого хамгаалах (эсхүл тахир дутуу болсны орлого) даатгал: Даатгуулагч өвчин тусах эсхүл аливаа гэмтлийн улмаас хөдөлмөрлөх чадваргүй болсон тохиолдолд тогтмол олгохоор заасан байдаг. Хөрөнгө оруулалтын санхүүгийн үйлчилгээний нийгэмлэгээс гаргасны дагуу тахир дутуу болсны орлогын даатгалын нөхөн төлбөр нь сард дунджаар 3'700 доллар байдаг байна.
- Гэмтлийн (хямрал) даатгал: Даатгуулагч тодорхой хугацаанд зүрхний шигдээс, хорт хавдар, цус харвалт зэрэг өвчний жагсаалтад багтсан өвчний аль нэг нь оношлогдсон тохиолдолд тохиролцсоны дагуу нэг удаагийн нөхөн төлбөр төлөхөөр заасан. Уг даатгалын нөхөн төлбөрийн дундаж хэмжээ 165'000 ам.доллар ба мөн хүнд өвчний даатгал нь санамсаргүй тохиолдлын даатгалд хамрагддаггүй байна⁶⁰.
- Өвчний болон гэнэтийн ослын даатгал: Санамсаргүй гэмтэл, өвчний улмаас учирсан хохирол, зардлыг нөхөх зорилгоор нэг удаагийн эсхүл тогтмол мөчлөгтэйгөөр ердийн даатгалд хамруулан олгодог.
- Аялал жуулчлалын даатгал: Аяллын явцад учирсан хохирол, зардал, түүний дотор эмчилгээний зардлыг нөхөхийн тулд тохиролцсон мөнгөн дүнг ердийн даатгалд хамруулан олгодог.

“Дээд шударга үнэний зарчим” буюу даатгуулагчийн мэдээллийг ил тод болгох үүрэг /Utmost Good faith/

Даатгагч болон даатгуулагчийн хооронд байгуулсан гэрээг даатгалын бодлогод тусгана. Даатгалын гэрээ нь “Дээд шударга үнэний зарчим” дээр суурилдаг гэрээний тусгай ангилалд багтдаг. Энэхүү зарчмын нэг элемент нь даатгуулагч нь нийтлэг хууль болон хууль тогтоомжийн дагуу мэдээлэл өгөх тусгай үүрэгтэй байдаг⁶¹. 1984 оны **Даатгалын гэрээний тухай хуулийн 21-р хэсэгт даатгуулагч нь даатгагчид хамааралтай, мэдэх шаардлагатай, үндэслэлтэй байх бүх мэдээллийг даатгагчид өгөх ёстой**⁶².

*Даатгуулагчийн генетикийн мэдээллийг цуглуулах, ашиглах*⁶³

Энэ тохиолдолд Хөрөнгө оруулалт санхүүгийн үйлчилгээний нийгэмлэгийн (IFSA) мэдээлснээр даатгуулагчийн гэр бүлийн өвчний түүхийг ашиглаж, гэр бүлийнхэнтэйгээ /гэр бүлийн/ удамшлын холбоотой тодорхой эрсдэлд өртөмтгий байх магадлалынх нь үндсэн дээр эрүүл мэндийн асуудалтай байх болзошгүй эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг.

⁵⁸ David Weisbrot and Brian Opeskin-Insurance and genetics: Regulating a private market in the public interest, Pn 126-127

⁵⁹ <https://www.alrc.gov.au/publication/essentially-yours-the-protection-of-human-genetic-information-in-australia-alrc-report-96/25-the-use-of-genetic-information-in-insurance/personal-insurance-in-australia/>, (Сүүлд үзсэн: 2023.01.03).

⁶⁰ Investment and Financial Services Association, Submission G049, 14 January 2002.

⁶¹ 1984 оны Даатгалын гэрээний тухай хууль /Insurance contract act/

⁶² [Insurance Contracts Act 1984 \(legislation.gov.au\)](https://www.legislation.gov.au/insurances/contracts/1984), (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁶³ Мөн тэнд, Эшлэл 62. 133 дахь тал.

Үүнд, эрсдэлийн зэрэгтэй даатгалын хувьд даатгуулагчийн гэр бүлийн эрүүл мэндийн түүхийн талаар асуулт тавьдаг. Тухайлбал: эцэг эх, ах, эгч нар нь амьд эсхүл нас барсан, зүрхний өвчин, цус харвалт, цусны даралт ихсэх, чихрийн шижин, хорт хавдар эсэх зэргээр өвчин эмгэгүүдийг тодорхойлдог.

Даатгалын харилцаа, түүнд холбогдох “гэнэтийн осол”, “осол” болон “өвчин”-ий ойлголт, эрх зүйн зохицуулалт

- Хамтын нөхөрлөлийн түвшинд, даатгалын салбар нь 1973 оны Даатгалын тухай хууль, 1984 оны Даатгалын гэрээний тухай хууль гэсэн үндсэн хоёр хууль тогтоомжоор зохицуулагддаг. Харин корпорацын тухай хуулийн 7-р бүлэгт төлөөлөгч, брокер зэрэг даатгалын зуучлагчдын тухай зохицуулдаг⁶⁴.
- АХУ-ын 1973 оны Даатгалын тухай хуулийн 3 дугаар бүлэгт зааснаар: **“Гэнэтийн ослын даатгалын үйл ажиллагаа” гэдэгт осол (үхэлд хүргэх үр дагавартай эсэхээс үл хамааран) эсхүл гэнэтийн осол, өвчин, эмгэг туссан тохиолдолд даатгалын бодлогын дагуу хариуцлага хүлээх үйл ажиллагааг ойлгоно гэжээ.**
- **HCF-ийн эрүүл мэндийн даатгалын компаниас хувийн гэнэтийн ослын даатгалд “осол” гэдэг үгт дараах тохиолдлууд хамаарна гэж үзсэн⁶⁵.** Үүнд:
 - Биеийн гадаад нөхцөл байдал;
 - Мэдэгдэхүйц;
 - Гэнэтийн;
 - Төлөвлөгдөөгүй тохиолдлууд хамаардаг. Үүнээс гадна, **даатгалд хамрах осолд “эмнэлгийн гаргасан тохиолдол, эрүүл мэндийн байдал, эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой хүндрэл” хамаарахгүй байна⁶⁶.**
- Ипотекийн зээлийн хамгаалалтын даатгал нь хэрэглээний зээлийн даатгалын нэг хэлбэр бөгөөд тодорхой нөхцөл байдалд орон сууцны зээлийн эргэн төлөлтийг хангах боломжгүй тохиолдолд төлбөр төлөхөд зориулагдсан болно.

Insurance Contracts Act-ын дагуу талууд нь шударга, нэгнээсээ чухал шаардлагатай мэдээллийг нуух, худал мэдүүлэхийг хориглох үүргийг тухайлсан байдаг. /Duty of utmost good faith/ Мөн даатгуулагч нь даатгагчийн шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц чухал мэдээллийг гаргаж өгөх шаардлагатай байдаг. /Duty of disclosure/ Хуулийн дагуу гэрээний бүхий л зүйлийг тусгасан баримтыг бичгээр даатгуулагчийн хүсэлтээр гаргаж өгөх үүрэгтэй байдаг.

2.5. ХБНГУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт⁶⁷

ХБНГУ-ын хувьд даатгалын салбарыг зохицуулах гол хуулиуд нь Даатгалын хяналтын тухай болон Даатгалын гэрээний тухай хууль юм.

Insurance Supervision act /Даатгалын хяналтын тухай хууль/: Даатгалын компаниуд Герман улсад үйл ажиллагаа явуулахын тулд **зөвшөөрөл авах шаардлагатай байдаг** бөгөөд ЕХ-ны бусад оронд зөвшөөрөл авсан даатгагч нь тухайн улсад үйл ажиллагаа явуулахад зөвшөөрлийг давхар авах шаардлагагүй байдаг байна.

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зөвхөн олон нийтийн хязгаарлагдмал хариуцлагатай компани, хамтын сан, нийтийн эрх зүйн байгууллагууд авах боломжтой

⁶⁴ https://www.alrc.gov.au/publication/grey-areas-age-barriers-to-work-in-commonwealth-laws-dp-78/4-insurance/insurance-in-australia/#_ftn3, (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁶⁵ <https://www.hcf.com.au/#>, (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁶⁶ [What is Mortgage Protection Insurance? | Cover Australia](#), (Сүүлд үзсэн: 2023.01.04).

⁶⁷ Даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, 2022 он, https://mof.gov.mn/files/uploads/discussion/1.1.%D0%94%D0%A2%D0%A5-%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D0%BD_%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0_0522_.pdf, (Сүүлд үзсэн: 2023.01.04).

бөгөөд үүнд даатгалын бүтээгдэхүүний бизнес төлөвлөгөө, давхар даатгалын бодлого, хангалттай нөөц сангийн баталгаа /даатгалын төрлөөс хамаардаг/ болон бизнес, борлуулалтын үйл ажиллагаа явуулах хөрөнгийн мэдээллийг бүрдүүлэх шаардлагатай.

Мөн 2 болон түүнээс дээш тооны удирдах ажилтнуудыг тухайн бизнесийг явуулах зохих чадвартай, байхыг шаарддаг.

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давхардуулан олгодоггүй байна. Тухайлбал, Амьдралын даатгалын компани ердийн даатгал буюу хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авах боломжгүй байдаг.

Даатгагч нь даатгалын бус бизнесийн үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх ёстой. Зохицуулах байгууллага нь даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлыг арилгуулах даалгавар өгөх эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцалдаг.

Түүнчлэн даатгагчийн эрх бүхий албан тушаалтан нь анхаарал, хариуцлагагүй ажилласан тохиолдолд тухайн ажил эрхлэхийг хориглох эрхтэй байдаг.

Insurance contracts Act /Даатгалын гэрээний тухай хууль/: Даатгалын гэрээний тухай хууль нь “хэрэглэгчийг хамгаалах суурь стандарт”-ыг тогтоосон байдаг. Зөвхөн зарим нэг тодорхой эрсдэлийн хувьд /агаарын хөлгийн, хөлөг онгоцны, тээвэрлэгдэх барааны, газрын тээврийн хариуцлагын, агаарын хөлөг болон усан онгоцны хариуцлагын/ хуульд зааснаас өөрөөр гэрээ байгуулахыг зөвшөөрдөг.

Даатгалын гэрээний тухай хуулиар усан тээвэр болон давхар даатгалыг зохицуулаагүй байдаг тул дээрх харилцаанд ХБНГУ-ын Иргэний хуулийг дагаж мөрддөг байна. 2008 онд хийсэн хуулийн шинэчилсэн найруулгаар **гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчийг даатгалын ерөнхий нөхцөл, заалт зэрэг холбогдох мэдээллээр хангахыг даатгагчид үүрэг болгосон. Ингэснээр даатгуулагч нарт мэдээлэлд үндэслэн шийдвэрээ гаргах боломжийг бүрдүүлсэн.** Даатгуулагчийн бүрдүүлсэн өргөдлийн нөхцөл, заалтуудад даатгагч зарим нэг өөрчлөлтийг оруулж болох боловч түүнийгээ даатгуулагчид мэдэгдэх ёстой байдаг. Тус мэдэгдлийг зохих журмын дагуу хүргүүлээгүй бол даатгуулагчийн тавьсан нөхцөл, заалтууд хүчин төгөлдөр гэж үздэг байна.

Мөн даатгагч нь гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчийн хэрэгцээ шаардлагыг тодруулж, зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд түүнийгээ баримтжуулах ёстой байдаг. Нийтийн эрх зүй бүхий орнуудаас ялгаатай нь даатгуулагч нь тухайлсан асуулт, тодруулга тавиагүй тохиолдолд даатгагчид эрсдэлтэй холбоотой мэдээллийг өгөх шаардлагагүй байхаар хуульчилсан. Харин усан тээвэр болон давхар даатгал нь өөр хуулийн хүрээнд зохицуулагддаг тул чухал мэдээллийг даатгуулагч өөрөө гаргаж тавих зарчим үйлчилдэг. Мөн томоохон эрсдэл болон нээлттэй даатгалын гэрээнд зарим нэг шаардлагыг хангахгүй байж болохоор тусгасан байна.

Даатгуулагч нь даатгагчид худал мэдээлэл өгч даатгалын гэрээг байгуулсан нь батлагдвал даатгагч гэрээг хүчингүй болгохоос гадна даатгалын тохиолдлыг шалгах, нягтлах зэрэг зардлыг нэхэмжлэх эрхтэй байхаар зохицуулсан байна.

Даатгалын гэрээний тухай хуулиар доорх гэрээнүүдийн агуулга, онцлог нөхцөл, хэм хэмжээг тусгайлан зохицуулсан байдаг. Үүнд: хөрөнгийн, хариуцлагын болон албан журмын, хуулийн зардлын, тээврийн, барилгын галын, амьдралын даатгалын, ажлын байрны ослын, гэнэтийн ослын, эрүүл мэндийн даатгалын гэрээ зэрэг болно.

2.6. ОХУ-ын даатгалын эрх зүйд холбогдох зохицуулалт

Гэнэтийн ослыг үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн осолтой холбоогүй гэнэтийн осол гэж хоёр хуваана.⁶⁸

ОХУ-ын хууль тогтоомжид “Үйлдвэрлэлийн осол” гэсэн тусдаа ойлголт байдаг. ОХУ-ын 1998 оны 7-р сарын 24-ний өдрийн N 125 “Үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай” хуулийн 3 дугаар зүйлд зааснаар **Үйлдвэрлэлийн осол** гэж даатгуулагчийг өөр ажилд шилжүүлэх, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүрмөсөн алдах, эсхүл нас барахад хүргэсэн энэ хуулиар тогтоосон бусад тохиолдлуудад даатгуулагчийн ажиллаж байгаа нутаг дэвсгэрийн хүрээнд болон түүний гадна талд эсхүл даатгуулагч өөрийнхөө тээврийн хэрэгслээр ажил руугаа явах үедээ эсвэл ажлаасаа буцаахдаа хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхдаа авсан гэмтэл эсвэл эрүүл мэндэд нь бусад хохирол учруулсан үйл явдал.⁶⁹ Жишээлбэл: Унаж бэртэх, халтирах, зам тээврийн аюул осолд өртөх, элдэв юманд цохиулах, хавчуулах, түлэгдэх, хорт хийнд хордох, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед болон цахилгаан хүчдэл, дэлбэрэлт, шаталт зэргийн нөлөөгөөр учирсан осол, химийн бодист хордох, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс гарч болох осол, бусдын гэмт үйлдлийн улмаас сум, хутга мэсэнд өртөх, хорлогдох, зодуулах, цохиулах гэх мэт.⁷⁰

ОХУ-ын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2011 оны 3-р сарын 10-ны өдрийн № 2 тоот “Шүүхүүд үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай хуулийг хэрэглэх нь” гэсэн тогтоолын 10 дахь заалтад зааснаар гэнэтийн ослыг үйлдвэрлэлийн болон **үйлдвэрлэлийн осолтой холбоогүй гэнэтийн осол** гэж ангилж болно (ийм нөхцөл байдлын бүрэн жагсаалтыг ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 229.2-р зүйлийн 6 дахь хэсэгт тусгасан).⁷¹ ОХУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн 229.2-р зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан дараахыг **үйлдвэрлэлийн гэнэтийн осолтой холбоогүй гэнэтийн осол гэж зүйлчилж болно.**

- Олон нийтийг хамарсан өвчнөөр эсвэл амиа хорлож нас барсан нь эмнэлгийн байгууллагаас, мөрдөн байцаах байгууллагаас эсвэл шүүхээс тогтоосон журмаар нотлогдсон;
- Эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр хохирогчийн үхэл эсвэл эрүүл мэндэд учирсан гэмтлийн цорын ганц шалтгаан нь техникийн спирт, анхилуун үнэрт, мансууруулах бодис болон бусад мансууруулах бодис ашиглах технологийн

⁶⁸ Официальный сайт Страховой компании “Согласие”// “Зөвшөөрөл” Даатгалын компанийн албан ёсны цахим хуудас <https://www.soglasie.ru/individuals/zdorovje/neschastnye-sluchai/>, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁶⁹ Федеральный закон “Об обязательном социальном страховании от несчастных случаев на производстве и профессиональных заболеваний” от 24.07.1998 N 125-ФЗ/(ОХУ-ын 1998 оны 7-р сарын 24-ний өдрийн N 125 “Үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай” хууль.) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_19559/, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷⁰ Официальный сайт Страховой компании “Согласие”// “Зөвшөөрөл” Даатгалын компанийн албан ёсны цахим хуудас, <https://www.soglasie.ru/individuals/zdorovje/neschastnye-sluchai/>, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷¹ Постановление Пленума Верховного Суда РФ от 10.03.2011 N 2 “О применении судами законодательства об обязательном социальном страховании от несчастных случаев на производстве и профессиональных заболеваний”/(ОХУ-ын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2011 оны 3-р сарын 10-ны өдрийн № 2 тоот “Шүүхүүд үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай хуулийг хэрэглэх нь” тогтоол) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_111595/, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

процессын зөрчилтэй холбоогүй согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх болон бусад мансууралт (хордлого);

- Хууль сахиулах байгууллагууд хохирогч эрүүгийн гэмт үйлдэл (эс үйлдэхүй) үйлдсэний улмаас гарсан осол гэж зүйлчлэх үйлдэл. (*Жишээлбэл: аргагүй хамгаалалт*).

Дээрхээс үзэхэд, **үйлдвэрлэлийн осолтой холбоогүй гэнэтийн осол** гэж олон нийтийг хамарсан өвчнөөр эсвэл амиа хорлож нас барсан нь эмнэлгийн байгууллагаас, мөрдөн байцаах байгууллагаас эсвэл шүүхээс тогтоосон журмаар нотлогдсон, эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр хохирогчийн үхэл эсвэл эрүүл мэндэд учирсан гэмтлийн цорын ганц шалтгаан нь техникийн спирт, анхилуун үнэрт, мансууруулах бодис болон бусад мансууруулах бодис ашиглах технологийн процессын зөрчилтэй холбоогүй согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх болон бусад мансууралт (хордлого), хууль сахиулах байгууллагууд хохирогч эрүүгийн гэмт үйлдэл (эс үйлдэхүй) үйлдсэний улмаас гарсан осол гэж зүйлчлэх үйлдлийг хэлнэ.

Осол, өвчин хоёр анагаахын ойлголт уу? Эрх зүйн ойлголт уу? Осол, гэнэтийн осол, өвчин, зам тээврийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, гэмтэл, хүний эрүүл мэндэд учирсан хохирол, онош, оношилгоо гэж юу вэ?: Осол, өвчин хоёр нь анагаахын ойлголт. **ОХУ-ын хууль тогтоомжид “осол” гэсэн үгийн тодорхойлолт байхгүй. Анагаах ухаанд осол гэдэг ойлголтоор эмчийн урьдчилан таамаглах болон урьдчилан сэргийлэх боломжгүй санамсаргүй нөхцөл байдалтай холбоотой эмчийн оролцооноос үүдэлтэй хагалгааны үед эсвэл хагалгаатай холбоогүй хүнийг эмчлэх үед гарсан муу үр дүнг ойлгоно. Мөн гэнэтийн осол гэж бие махбодод гэмтэл учруулахад эсвэл үхэлд хүргэсэн гэнэтийн гаднын нөлөөтэй үйл явдлаас үүдэлтэй урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлыг хэлнэ.**⁷²

2011 оны 11-р сарын 21-ний өдрийн N 323 "ОХУ-ын иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зарчмуудын тухай" хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад зааснаар **өвчин** гэж эмгэг төрүүлэгч хүчин зүйлсийн нөлөөллөөс үүдэлтэй биеийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар, гадаад, дотоод орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар, бие махбодын хамгаалалтын - нөхөн өгөгч, хамгаалалтын - дасан зохицох реакцийг болон механизмыг нэгэн зэрэг өөрчлөхийг хэлнэ.⁷³

Зам тээврийн осол гэж зам дээр тээврийн хэрэгсэл явж байх явцад болон түүний оролцооноос үүдэлтэй хүний амь нас эндсэн эсвэл хүмүүс гэмтсэн, тээврийн хэрэгслүүд эвдэрсэн, барилга байгууламж нуурсан, ачаанууд урагдаж гэмтсэн эсвэл бусад материаллаг хохирол учирсан үйл явдлыг хэлнэ.⁷⁴

ОХУ-ын 1998 оны 7-р сарын 24-ний өдрийн N 125 үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай" хуулийн 3 дугаар зүйлд

⁷² Шипилова Д.С. Разграничение понятий «медицинская ошибка», «несчастные случаи», «дефект оказания медицинской помощи» и «ятрогения».Международный журнал гуманитарных и естественных наук 2021 г. // (Шипилова Д.С.Анагаахын алдаа, "осол", "эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал", "биеийн байдал муудах" гэсэн ойлголтуудыг ялгах нь. олон улсын хүмүүнлэгийн болон байгалийн шинжлэх ухааны сэтгүүл 2021 он) <https://cyberleninka.ru/article/n/razgranichenie-ponyatiy-meditsinskaya-oshibka-neschastnye-sluchai-defekt-okazaniya-meditsinskoy-pomoschi-i-yatrogeniya>, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷³ Федеральный закон "Об основах охраны здоровья граждан в Российской Федерации" от 21.11.2011 N 323-ФЗ/(2011 оны 11-р сарын 21-ний өдрийн N 323 "ОХУ-ын иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зарчмуудын тухай" хууль) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_121895/ (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷⁴ Федеральный закон "О безопасности дорожного движения" от 10.12.1995 N 196-ФЗ // (ОХУ-ын 1995.12.10-ны өдрийн N 196 "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль") http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_8585/ (Сүүлд үзсэн: 2023.01.05).

зааснаар **мэргэжлээс шалтгаалах өвчин** гэж хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалсан болон хөдөлмөрийн чадвараа түр буюу бүрмөсөн алдахад, (эсвэл) нас барахад хүргэсэн даатгуулагчийн архаг эсвэл цочмог өвчнийг ойлгоно.⁷⁵

Гэмтэл гэж ямар нэг гаднын хүчин зүйлсийн нөлөөгөөр биеийн эд эсэд хохирол учруулах, түүнчлэн биеийн эрхтнүүдийн хэвийн үйл ажиллагаа явуулахад саад учруулахыг хэлнэ.

Хүний эрүүл мэндэд учирсан хохирол гэж гадна орчны физик, хими, биологийн, сэтгэцэд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөгөөр анатомийн бүрэн бүтэн байдал мөн хүний эрхтнүүдийн болон арьсны физиологийн функцийг зөрчихийг хэлнэ.⁷⁶

Онош гэж (грек. διάγνωσις, лат. diagnosis «тодорхойлох»; dia «тусдаа» +gnosis «мэдлэг») өвчтөний үзлэгийг үндэслэж өвчнийг нь тодорхойлохыг хэлнэ.⁷⁷ 2011 оны 11-р сарын 21-ний өдрийн N 323 "ОХУ-ын иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зарчмуудын тухай" хуулийн 2 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар **оношилгоо** гэж биеийн байдлыг тодорхойлоход эсвэл өвчтөн өөрөө болон түүний хажуу дахь хүмүүсийн хэлснээр өвчтөний үзлэгийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх замаар түүнд өвчин байгаа эсвэл байхгүй эсэхийг тогтоох, мөн лаборатори, багажийн, анатомийн болон бусад үзлэгийн аргаар өвчтөнийг эмчлэх аргыг сонгох болон (эсвэл) эдгээр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зорилготой анагаахын оролцооны цогцыг ойлгоно.⁷⁸

Амь насны даатгал хийлгэсэн хүн гэнэтийн осолд өртвөл нөхөн төлбөр авах боломжтой юу?: Амь насны даатгал хийлгэхийг хүссэн хүнтэй даатгагч амь насны даатгалын гэрээ байгуулахдаа ОХУ-ын Иргэний хуулийн 943 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу тус гэрээнд тухайн даатгагчийн даатгалын дүрмийг хавсаргаж, тус гэрээнд (даатгалын полист) ийм дүрмийг хэрэглэхийг шууд зааж өгсөн тохиолдолд тухайн даатгалын гэрээнд эсвэл даатгалын дүрэмд амь насны даатгал хийлгэсэн хүн гэнэтийн осолд өөртвөл нөхөн төлбөр олгоно гэж заасан тохиолдолд нөхөн төлбөр авах боломжтой.

Харин гэрээнд, ОХУ-ын Иргэний хуулийн 943 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу гэрээтэй хавсаргасан даатгалын дүрэмд амь насны даатгал хийлгэсэн хүн гэнэтийн осолд өөртвөл нөхөн төлбөр олгоно" гэж заагаагүй тохиолдолд амь насны даатгал хийлгэсэн хүн гэнэтийн осолд өөртвөл нөхөн төлбөр авах боломжгүй.

⁷⁵ Федеральный закон "Об обязательном социальном страховании от несчастных случаев на производстве и профессиональных заболеваний" от 24.07.1998 N 125-ФЗ/(ОХУ-ын 1998 оны 7-р сарын 24-ний өдрийн N 125 үйлдвэрлэлийн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд заавал даатгуулах тухай" хууль.) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_19559/ (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷⁶ Приказ Минздравсоцразвития РФ от 24.04.2008 N 194н (ред. от 18.01.2012) "Об утверждении Медицинских критериев определения степени тяжести вреда, причиненного здоровью человека" (Зарегистрировано в Минюсте РФ 13.08.2008 N 12118)/(ОХУ-ын Эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн яамны 2008 оны 4-р сарын 24-ний өдрийн N 194н (2012 оны 1-р сарын 18-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан) "Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шатлалыг тодорхойлох эмнэлгийн шалгуурыг батлах тухай"тушаал (ОХУ-ын Хууль зүйн яаманд 2008 оны 8-р сарын 13-ны N 12118 бүртгэгдсэн) <https://base.garant.ru/12162210/> (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷⁷ Диагноз // Энциклопедический словарь Брокгауза и Ефрона : в 86 т. (82 т. и 4 доп.). — СПб., 1890—1907. //(Оношлогоо // Брокгауза ба Эфроны Нэвтэрхий толь бичиг: 86 боть (82 боть болон 4 нэмэлт). - Санкт-Петербург., 1890-1907.) <https://gufo.me/amp/dict/brockhaus/%D0%94%D0%B8%D0%B0%D0%B3%D0%BD%D0%BE%D0%B7> (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁷⁸ Федеральный закон "Об основах охраны здоровья граждан в Российской Федерации" от 21.11.2011 N 323-ФЗ/(2011 оны 11-р сарын 21-ний өдрийн N 323 "ОХУ-ын иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зарчмуудын тухай" хууль) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_121895/ (Сүүлд үзсэн: 2023.01.05).

Иргэний хуулийн 934 дүгээр зүйл. **Хувь хүний даатгалын гэрээ** (Амь насны даатгал).

1. Хувь хүний даатгалын гэрээгээр нэг тал (даатгагч) нөгөө талын (даатгуулагчийн) төлсөн даатгалын хураамжийг үндэслэж, даатгуулагчийн өөрийн болон гэрээнд заасан өөр иргэний (даатгуулагч этгээдийн) амь нас эсвэл эрүүл мэндэд хохирол учирсан эсвэл тэрээр тодорхой насанд хүрсэн эсвэл түүний амьдралд **гэрээнд заасан** өөр нөхцөл байдал (даатгалын тохиолдол) тохиолдсон тухай бүрд эсвэл үе үе гэрээнд заасан даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүрэгтэй.

Даатгалын гэрээг даатгагчтай байгуулсан этгээд даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй.⁷⁹

Гэнэтийн осол гэж бие махбодод гэмтэл учруулахад эсвэл үхэлд хүргэсэн гэнэтийн гаднын нөлөөтэй үйл явдлаас үүдэлтэй урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлыг хэлнэ. Жишээлбэл: хүн ажил дээрээ гэмтэл авсан, осолд орсон гэх мэт. Гаднын нөлөөтэй үйл явдлаас үүдэлтэй нөхцөл байдал биш учраас тархины цус харвалт, зүрхний шигдээс нь гэнэтийн осолд хамаарахгүй. Энэ шалтгааны улмаас үхлийн аюултай өвчний болон гэнэтийн ослын даатгалын хөтөлбөрүүд нь хоёр өөр төрлийн амь нас болон эрүүл мэндийг даатгуулах даатгалын төрлүүд нь юм.

Үхлийн аюултай өвчнөөр өвдсөн (цус харвах, зүрхний шигдээс гэх мэт) болон гэнэтийн осолд орсон гэсэн шалтгаанаар даатгалын нөхөн төлбөрийг авахын тулд даатгалын хоёр хөтөлбөрийг хамтад нь даатгалын гэрээ байгуулахдаа даатгалын гэрээндээ оруулж болно.

Хэрвээ дээрх 2 хөтөлбөрийн зөвхөн нэгийг нь буюу гэнэтийн ослын хөтөлбөрийг нь даатгалын гэрээндээ оруулж, гэрээ байгуулбал, тухайн гэнэтийн ослын хөтөлбөрийг даатгалын гэрээндээ оруулж, гэрээ байгуулсан хүн үхлийн аюултай өвчнөөр (жишээлбэл: цус харвасан) өвдсөн тохиолдолд тухайн хүн үхлийн аюултай өвчнөөр өвдсөн гэж даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй. Учир нь даатгалын гэрээнд үхлийн аюултай өвчнөөр өвдсөн тохиолдолд нөхөн төлбөр авах боломжтой гэж тусгаагүй учраас.⁸⁰

Юу юуг гэнэтийн осол гэж үздэггүй вэ?: Цус харвалт гэж мэдрэлийн эсийг гэмтээж, тархинд гэмтэл учруулахад хүргэдэг цусны эргэлт өөрчлөгдөхийг хэлнэ.⁸¹ Анагаах ухааны доктор, профессор Владимир Владимирович Захаров цус харвалтыг өвчин биш, зүрх судасны өвдөлтийн хүндрэл гэсэн байна.⁸²

⁷⁹ Гражданский кодекс Российской Федерации часть 2 (ГК РФ ч.2) от 26 января 1996 года № 14-ФЗ/ 1996 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн № 14 Оросын Холбооны Улсын Иргэний хууль 2-р хэсэг (ОХУ-ын ИХ 2-р хэсэг) http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_9027/ (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁸⁰ Официальный сайт «Страховой компании Райффайзен Лайф»// Райффайзен Лайф даатгалын компанийн албан ёсны цахим хуудас). <https://www.raiffeisen-life.ru/useful-info/yavlyayutsya-li-insult-i-infarkt-neschastnyimi-sluchayami-pri-strakhovanii/> (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁸¹ Штульман Д.Р. Неврология: Справочник практического врача / Д.Р. Штульман, О.С. Левин. – 6–е изд., доп. и перераб.– М.: МЕДпресс–информ, 2008. – 435 с.// Штульман Д.Р. Мэдрэл судлал: Эмчийн гарын авлага / Д.Р. Штульман, О.С. Левин. - 6-р хэвлэл, нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн. - М.: МЕДпресс–информ, 2008. – 435 х. URL: <http://www.almazovcentre.ru/wpcontent/uploads/%D0%94%D0%B8%D1%81%D1%81%D0%B5%D1%80%D1%82%D0%B0%D1%86%D0%B8%D1%8F-.pdf> (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁸² Владимир Владимирович Захаров, д.м.н, профессору кафедры нервных болезней и нейрохирургии Сеченовского Университета “Инсульт – это не болезнь, а осложнение ССЗ” от 19.11.2019// (2019.11.19-ний өдөр Сеченовын нэрэмжит их сургуулийн мэдрэлийн өвчин, мэдрэлийн мэс заслын тэнхимийн анагаах ухааны доктор, профессор Владимир Владимирович Захаровын хэлснээр “Цус харвалт өвчин биш, харин зүрх судасны өвдөлтийн хүндрэл”). <https://medvestnik.ru/content/interviews/Insult-eto-ne-bolezn-a-oslojnenie-SSZ.html>, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

ОХУ-ын Иргэний хуулийн 943 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт даатгалын гэрээ байгуулах нөхцөлийг даатгагч эсхүл даатгагчдын холбоо баталсан хүлээн зөвшөөрсөн эсвэл баталгаажуулсан холбогдох төрлийн даатгалын стандарт дүрмээр (даатгалын дүрмээр) тодорхойлж болно” гэж зааснаар гэнэтийн осол гэж үздэггүй нөхцөлүүдийг даатгагчийн дотооддоо баталсан дүрэмд заасны дагуу зохицуулна. Тухайлбал: ВСК Даатгалын байшин гэсэн нэртэй даатгагчийн “Иргэдийн гэнэтийн ослын болон өвчний сайн дурын даатгалын тухай № 83 дүрмийн 2 дахь хэсгийн 2.4. дэх заалтад гэнэтийн осолд цочмог, архаг болон удамшлын өвчинд хамаардаг аль ч хэлбэрийн өвчин (мөн зүрхний шигдээс, цус харвалт болон удамшлын эмгэгийн улмаас үүссэн бусад гэнэтийн эрхтний гэмтэл эсвэл удамшлын өвчний хөгжлийн үр дүнд үүссэн эмгэг) халдварт өвчин (хачигт энцефалит /хачигт энцефаломиелит/,полиомиелитээс бусад) өөрөөр заагаагүй бол орохгүй”⁸³ гэж заасан байна.

"СМП-Даатгал" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани нэртэй даатгагчийн 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Хувь хүний гэнэтийн ослын даатгалын дүрмийн” 1 дүгээр хэсгийн 1.10 дахь заалтад зааснаар гэнэтийн осолд цочмог, архаг болон удамшлын өвчинд хамаардаг аль ч хэлбэрийн өвчин (мөн зүрхний шигдээс, цус харвалт болон удамшлын эмгэгийн улмаас үүссэн бусад гэнэтийн эрхтний гэмтэл эсвэл удамшлын өвчний хөгжлийн үр дүнд үүссэн эмгэг) орохгүй.⁸⁴

⁸³ Правила Страхового Дома ВСК № 83 “Добровольного страхования граждан от несчастных случаев и болезней” «01»ноября 2017г// ВСК Даатгалын байшин 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн “Иргэдийн гэнэтийн ослын болон өвчний сайн дурын даатгалын тухай № 83 дүрэм” <https://polis812.ru/api/program/downloadFile/224/vsk-rules.pdf> (Сүүлд үзсэн: 2023.01.05).

⁸⁴ Общество с ограниченной ответственностью «Смп-страхование» Правила страхования физических лиц от несчастных случаев от 27.03.2017//("СМП-Даатгал" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани 2017.03.27 Хувь хүний гэнэтийн ослын даатгалын дүрэм). URL: <https://www.smpins.ru/upload/iblock/16d/102%20%D0%9F%D1%80%D0%B0%D0%B2%D0%B8%D0%B%D0%B0%20%D1%81%D1%82%D1%80%D0%B0%D1%85%20%D1%84%D0%B8%D0%B7%20%D0%BB%D0%B8%D1%86%20%D0%BE%D1%82%20%D0%BD%D1%81%20291217.pdf>, (Сүүлд үзсэн: 2023.01.05).

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд “осол”, “гэнэтийн осол”, “өвчин” гэсэн нэр томъёоны ойлголтыг эрх зүйн шинжлэх ухаанд болон анагаахын шинжлэх ухаанд хэрхэн ойлгодог талаар судлан, даатгалын эрх зүйн тус ойлголтуудын агуулгыг харьцуулсан судалгааны хүрээнд судалж дараах дүгнэлтийг хийв:

Даатгал нь ирээдүйн үйлчилгээг одоо худалдаж авах үйл явц болохын хувьд ирээдүйд гарч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах чухал хэрэгслийн нэг бөгөөд даатгуулагчид гэрээнд заасан хохирол учирсан үед хохирлыг нөхөн төлөх, хохирлоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй байдаг.

Даатгалыг хугацааны хувьд ердийн даатгал, урт хугацааны даатгал гэж ангилдаг. Даатгал нь албан журмын даатгал (заавал даатгал), сайн дурын даатгал гэсэн төрлөөс бүрддэг. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно. Харин сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоодог.

Даатгалын эрх зүй болон түүнд хамаатай “даатгал” гэдэг ойлголтыг “даатгалын гэрээний үндсэнд үүсдэг даатгалын компани болон даатгуулагч нарын хооронд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг зохистойгоор удирдах, бууруулахад чиглэсэн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний цогц” гэж тодорхойлж болно. Энэ нь дан ганц эрх зүйн ойлголт бус эдийн засаг, цаашилбал анагаахын шинжлэх ухаантай ч мөн тодорхой хэсгээрээ огтлолцон холбогдоно.

Эрх зүйн тэр дундаа, даатгалын эрх зүйд хамаарах “гэнэтийн осол”, “осол”, “өвчин” гэх ойлголтууд нь өөр өөр шинжлэх ухааны салбар тус бүрд олон янзын утга илэрхийлэх тул тус ойлголтуудыг “плюрал” шинжтэй ухагдахуунууд юм гэж дүгнэх боломжтой байна гэж үзсэн. Жишээ нь: анагаахын шинжлэх ухааны судлагдахуун болох “өвчин”, “осол”-ын ойлголт нь эрх зүйн нэр томъёоны хэрэглээний хувьд эрүүгийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг, “эрсдэл”, “даатгал” гэх ойлголтууд нь анагаахын шинжлэх ухааны салбараас илүү эрх зүйн шинжлэх ухаанд илүүтэй хэрэглэгддэг ойлголтууд юм.

Даатгал нь өөрөө хосолмол шинжтэй ухагдахуун болохын хувьд “даатгал”, “гэнэтийн осол”, “өвчин” зэрэг ойлголтуудыг монгол хэлний нэр томъёоны их тайлбар тольд хэрхэн тайлбарласан зэргээс нь эхлэн судалсан болно. Улмаар Монгол Улсын хууль тогтоомжид “өвчин” болон “гэнэтийн осол” гэсэн ойлголтыг тайлбарлан тодорхойлсон эсэх талаар судалгаа хийхэд аливаа хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт тус ойлголтуудыг тайлбарласан тохиолдол байгаагүй болно.

Даатгалыг ангилах тухайд, дурдсанчлан түүнийг ердийн болон урт хугацааны даатгал гэсэн ангилалд хувааж болох ба ийнхүү ангилах нь эрх зүйн ач холбогдолтой. Учир нь Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэгт “урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохгүй” гэж зааснаас үзвэл дээрх 2 төрлийн үйл ажиллагаа нь зааг ялгаатай ба тус үйл ажиллагааг эрхлэх этгээд ч ялгамжтай (тусдаа) байхаар зохицуулсан байна. Иймээс дотоодын эрх зүйн зохицуулалтын хувьд ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд урт хугацааны буюу амьдралын даатгалын үйл ажиллагаа эрхэлж болохгүй гэж дүгнэх боломжтой. Ингэснээр даатгалын хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаа давхцахгүй байх ач холбогдолтой билээ.

Даатгалыг дотор нь нарийвчилсан чиглэлээр ихээхэн олон төрөлд хувааж үзэж болох ба энэ нь даатгуулагчийн хүсэл зоригтой шууд хамааралтай. Даатгалын, тэр дундаа

урт хугацааны даатгалын нэг хэлбэр нь амьдралын даатгал юм. Харин гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал зэрэг даатгалын төрлүүд нь урт болон богино хугацааны даатгалд хамаарах ба ихэнх тохиолдолд тодорхой хугацаагаар байгуулан, хугацаа дууссаны дараа сунгуулах нөхцөлтэй байгуулагддаг байна.

Амь насны даатгал нь өөрөө тодорхой эрсдэлүүдээс даатгуулагчийг хамгаалах зорилгоор байгуулагддаг ба үүнд ихэнх тохиолдолд “осол” болон “бүх төрлийн өвчин” хамаарахаар “ухуулга, сурталчилгаа” явуулж тухайн компанийн танилцуулгад тусгасан байх боловч практикт өвчин, ердийн өвчнөөс үүдэн нас барсан, хөдөлмөрийн чадвараа тодорхой хувь, хэмжээгээр алдсан тохиолдолд нөхөн төлбөр олгодоггүй байна.

2022 онд Даатгалын тухай уулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, батлах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо мөн *“Ипотекийн зээлийн гэрээ нь 10-аас дээш жилээр хийгдэж байгаа боловч урт хугацаанд хувь хүнд үүсэх өвчин эмгэг зэргийг гэнэтийн ослын даатгалын тохиолдолд тооцдоггүй нь даатгаагч, даатгуулагчийн хооронд үүсэж буй маргааны нэг шалтгаан болж байна.”* гэснээс энэ төрлийн маргаан даатгалын эрх зүйн хөгжлийг шаардаж байна гэж үзэх боломжтой байж болох юм.

Зарим тохиолдолд сурталчилгаанд заасан нөхцөлөөр бус даатгуулагчтай байгуулж буй даатгалын гэрээнд “гэнэтийн осол” гэдгийг тодорхойлохдоо “өвчнөөс бусад ...” гэж тусгасан, даатгалын гэрээгээр хамгаалагдах эрсдэлд өвчин (зүрхний шигдээс, цас харвалт)-ий эрсдэл хамааруулах бол нэмж төлбөр, хураамж төлөх байдлаар зохицуулах нь практикт даатгуулагчтай байгуулж буй даатгалын гэрээнд түгээмэл байдаг байна.

“Өвчин” нь анагаахын шинжлэх ухааны ойлголт болохын хувьд тодорхой шалтгаанаар үүсгэгддэг эрүүл мэндийн гажуудал юм.

Харин даатгуулагчийн зүгээс хамгаалагдаж буй эрсдэл буюу “гэнэтийн осол” нь дийлэнхдээ гаднын нөлөөгөөр үүсгэгдсэн, санамсаргүй буюу болгоомжгүй шинжтэй, нэг удаагийн, урьдчилан таамаглах боломжгүй, хурдан хугацаанд болоод өнгөрөх гэнэтийн шинжтэй эрүүл мэндийн хэвийн байдал алдагдсан тохиолдлыг ойлгоно. Жишээ нь: машинд мөргүүлэх, нохойд хазуулах г.м.

“Осол”, “өвчин” гэх хоёр ойлголтын ялгаа, заагийг хэрхэн тодруулах нь маргаан бүхий тохиолдолд болон тохиолдлоос үүссэн маргаан бүхий харилцааны оролцогч нарын эрүүл мэндийн байдал, түүний талаар мэдээлэл, түүнийг нь мэдсэн, мэдээлсэн, лавлаж тодруулсан эсэх даатгалын компанийн үйл ажиллагаатай холбогдоно гэж үзлээ. Учир нь дээрх хоёр ойлголтын заагийг нарийн ялган, тогтоон хуульчилсан явдал харьцуулсан судалгааны хүрээнд сонгон авсан улсын хууль тогтоомж, эрх зүйн бусад эх сурвалжид байгаагүй болно. Гэсэн хэдий ч энэхүү асуудалтай холбоотойгоор маргаан гарсан тохиолдолд шийдвэрлэж буй шүүхийн практик харьцангуй “уян хатан” болж эхэлж байгаа гэж дэлхийн хөгжингүй улсын нэгд зүй ёсоор тооцогдог ИБУИНХУ, ХБНГУ-ын жишээнээс харж болохоор байна.

ИБУИНХУ-ын хувьд даатгалын гэрээний төрлүүдийг нарийвчлан хөгжүүлсэн, маргаан үүссэн тохиолдолд суурь даатгалын гэрээний зарчмыг чухалчлан баримталдаг онцлогтой. Тус улсын даатгалын эрх зүйн хууль тогтоомжуудад эрүүл мэндийн болон амь насны даатгалын гэрээнд өвчин гэх ойлголтыг хэрхэн ойлгож тодорхойлох талаарх албан ёсны тодорхойлолтыг хуульчлаагүй байна. Харин даатгуулагч нь ямар төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх гэж байгаагаас хамааруулан хоорондоо нарийн ялгаа бүхий даатгалын гэрээний төрлүүд хөгжсөн байна. Тухайлбал, өвчний улмаас эрүүл мэндийн хүнд нөхцөлд орж санхүүгийн хүндрэлд орохоос сэргийлэх зорилгоор *“critical illness insurance”*

буюу хүнд өвчний даатгалд даатгуулах, өвчний улмаас нас барсан тохиолдолд үүсэх эрсдэлээс сэргийлэх бол амь насны даатгалд даатгуулах гэх мэт.

Амь насны даатгал нь даатгуулагчийг нас барсан шалтгаанаас хамааруулан нарийн ялгаа бүхий ослын, моргажийн гэх мэтчилэн хэд хэдэн дэд төрлүүдтэй. Дээрх даатгалын гэрээнүүдтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд “*good faith/utmost good faith*” буюу шударга үнэний зарчим (харилцан итгэлцлийн зарчим) чухал ач холбогдолтой.

Тус зарчмын дагуу даатгуулагч нь даатгуулах гэж буй эрсдэлтэй холбоотой бүхий л мэдээллийг үнэнч шударгаар гаргаж өгөх, даатгагч нь тус мэдээлэлд няхуур хянамгай хандах үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй нөхцөлд даатгагч нь даатгалын нөхөн төлбөрийг төлөхөөс татгалзах, гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулах хүртэлх эрхтэй. Гэсэн хэдий ч тухайн маргааны онцлог, нөхцөл байдлаас хамаарч даатгуулагчийн үүргийн зөрчлийг үгүйсгэх нөхцөлүүдийг хуульчилсан байна.

Тохиолдолд үүссэн маргаантай төстэй тохиолдол БНСУ-д үүссэн бол хэрхэн байсан талаар эрх зүйн зохицуулалтыг судлахад маргаан бүхий харилцаатай холбоотой БНСУ-ын даатгалын салбар нь ипотекийн зээлийн үйлчилгээтэй хавсран даатгалын үзүүлдэг. Ингэхдээ тухайн ипотекийн зээлээр олгож буй орон сууцандаа даатгал хийж учирч болзошгүй эрсдэлээс сэргийлдэг.

Мөн даатгал хөгжсөн дэлхийн улсуудаас БНСУ-ын даатгалын эрх зүйн салбар харьцангуй өндөр хөгжсөн улсад багтах тул иргэд нь даатгалд өргөнөөр хамрагддаг. Албан ёсоор хөдөлмөр эрхэлж буй иргэн заавал хөдөлмөрийн даатгал төлдөг бөгөөд ажлаас халагдах, орон тооны цомхотголд ороход нөхөн төлбөр олгодог. Эрүүл мэндийн даатгал нь заавал төлөх даатгал бөгөөд давхар өвчний даатгал мөн төлдөг байна.

Япон Улсын хувьд ипотекийн зээл авч буй иргэд амьдралын даатгал хийлгэх үүрэгтэй ба тус улсын Даатгалын тухай хуулиар мөн даатгуулагчийн зүгээс даатгагчид даатгалын гэрээний бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийн мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөх үүргийг тусгасан онцлогтой.

АХУ, ХБНГУ-ын хувьд даатгалын эх зүйн эх сурвалж буюу холбогдох хуульд “*good faith/utmost good faith*” буюу шударга үнэний зарчим (харилцан итгэлцлийн зарчим) тусгагдсан.

Энэ нь нэг талаас даатгуулагчийг даатгалын гэрээний бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийн мэдээллийг үнэн зөвөөр гаргаж өгөх үүрэг хүлээлгэхийн зэрэгцээ даатгуулагчид түүнийг нь нягтлах, эс бөгөөс даатгуулагчид нөхөн төлбөр олгохоос татгалзаж үл болохоор зохицуулсан.

Түүнчлэн ХБНГУ-ын зохицуулалтын хувьд даатгагч нь гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчийн хэрэгцээ шаардлагыг тодруулж, зөвлөгөө өгөх үүрэгтэй бөгөөд түүнийгээ баримтжуулах ёстой. Тухайлсан асуултыг даатгагчийн зүгээс асууж мэдээлэл авч чадаагүй нь нөхөн төлбөр олгохоос татгалзах үндэслэл болохгүй гэсэнээрээ бусад “шударга үнэний зарчим (харилцан итгэлцлийн зарчим)”-ыг даатгалын эрх зүйн салбарт нэвтрүүлсэн орнуудаас ялгаатай байна.

ОХУ-ын эрх зүйн зохицуулалт харьцуулсан судалгааны хүрээнд судалсан дэлхийн бусад улсынхаас харьцангуй өөр буюу өвчин (үүнд цус харвалт, зүрхний шигдээс хамаарна)-ийг гэнэтийн осол гэж үздэггүй, иймээс даатгалын гэрээгээр нөхөн төлбөр шаардах эрхгүй байдаг гэдгээрээ Монгол Улсын даатгалын гэрээний зохицуулалттай ихээхэн төстэй.

Учир нь ОХУ-ын хувьд даатгуулагч нь “өвчин”-д хамаарах зүрхний шигдээс, цус харвалтыг эрсдэлийг даатгуулах тохиолдолд тухайн ангиллыг сонгох шаардлагатай ба ийнхүү даатгалын эрсдэлд тус өвчнийг хамруулаагүй тохиолдолд даатгуулагчийн зүгээс нөхөн төлбөр шаардах эрхгүй болдог байна.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Ард даатгал болон Хаан даатгалын албан ёсны цахим хуудаст хандан тус мэдээллийг олж авсан болно. <https://arddaatgal.mn>
2. Даатгалын ач холбогдол (гарын авлага), Монгол банк, 2020 он. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/26.pdf>
3. Даатгалын ач холбогдол (гарын авлага), Монгол банк, 2020 он. <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/26.pdf>
4. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага, 2022 он, https://mof.gov.mn/files/uploads/discussion/1.1.%D0%94%D0%A2%D0%A5-%D0%B8%D0%B9%D0%BD_%D1%82%D0%B0%D0%BD%D0%B4%D0%B0%D0%BD_%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0_0522_.pdf
5. Санхүүгийн зохицуулах хороо, Өргөдөл гомдлын судалгаа, 2018, 2019, 2020.
6. С.Нарангэрэл-Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг. УБ хот, 2015 он, 330 дахь тал.
7. Ц.Цэцэгмаа, Б.Оюунбат-Эмгэг үйл судлал, УБ хот, 2004 он, 10 дахь тал
8. <https://khaandaatgal.mn>
9. <https://www.zurich.ch>
10. <https://www.sankhuugjinbolovsrol.mn/cdn/pdf/Huvi%20hun%20buleq14.pdf>
11. <https://mongoltoli.mn/dictionary/detail/28013>
http://www.frc.mn/resource/frc/uploads/news/files/frc_imd_15_gariin%20avлага_geneteiin%20osliin%20daatgaliin%20gariin%20avлага.pdf
12. <https://mongoltoli.mn/dictionary/detail/29026>

Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. David Weisbrot and Brian Opeskin-Insurance and genetics: Regulating a private market in the public interest, Pn 126-127
2. Dina Esmaeil M Abuzaid, Reform of the Doctrine of Utmost Good Faith: A Company study between the UK and Suadi Arabia (thesis for doctoral degree), UK, 2018, p.56 <https://dspace.stir.ac.uk/bitstream/1893/28038/1/PhD%20Thesis%20-%20Dina%20Abuzaid-%2010102018.pdf>
3. Seiichi Ochiai, Shinichi Takahashi and Ryoko Takeda, "Japan: the insurance concept in the Insurance Act and the Insurance Business Act", 2012. <https://housekey.jp/set-up-life-insurance-for-mortgage-home-loan-japan/>
4. The Insurance and Reinsurance Law Review - The Law Reviews
5. <https://www.legislation.gov.uk/ukxi/2001/544/contents/made>
6. <https://www.investopedia.com/terms/a/accidental-death-benefit.asp>
7. <https://www.thetimes.co.uk/money-mentor/article/mortgage-life-insurance/>
<https://www.forbes.com/advisor/life-insurance/mortgage-life-insurance/>
8. <https://www.unbiased.co.uk/discover/insurance/critical-illness-insurance/what-is-critical-illness-insurance-and-do-i-need-it>
9. [https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-501-2031?transitionType=Default&contextData=\(sc.Default\)&firstPage=true#co_anchor_a798742](https://uk.practicallaw.thomsonreuters.com/0-501-2031?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a798742)
10. https://www.kbinsure.co.kr/images/claim_svc/reqdoc_genal.pdf
11. <https://insurance.maryland.gov/%ED%95%9C%EA%B5%AD%EC%96%B4/Documents/ConsumerGuideHomeownersInsKorean.pdf>
12. <https://www.alrc.gov.au/publication/essentially-yours-the-protection-of-human-genetic-information-in-australia-alrc-report-96/25-the-use-of-genetic-information-in-insurance/personal-insurance-in-australia/>

13. <https://thelawreviews.co.uk/title/the-insurance-disputes-law-review/united-kingdom-england--wales>
14. https://www.alrc.gov.au/publication/grey-areas-age-barriers-to-work-in-commonwealth-laws-dp-78/4-insurance/insurance-in-australia/#_ftn
15. <https://www.hcf.com.au/#>

Хууль тогтоомж:

1. Consumer insurance contract Act.
2. Consumer Insurance Act, 2012.
3. Financial Service and Market Act, 2000.
4. Insurance Act, 2015.
5. 보험업법, Insurance Business Act.
6. Insurance Act, 2008.
7. Insurance Business Act, 1995.
8. Investment and Financial Services Association, Submission G049, 14 January 2002.
9. Insurance Contracts Act, 1984.
10. Marine Insurance Act, 1906.
11. National Life Insurance Act.
12. Non-consumer insurance contract.

Орос хэл дээрх эх сурвалж:

1. Владимир Владимирович Захаров, д.м.н, профессору кафедры нервных болезней и нейрохирургии Сеченовского Университета “Инсульт – это не болезнь, а осложнение ССЗ” <https://medvestnik.ru/content/interviews/Insult-eto-ne-bolezn-a-oslojnenie-SSZ.html>
2. Гражданский кодекс Российской Федерации часть 2 (ГК РФ ч.2) от 26 января 1996 года № 14-ФЗ http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_9027
3. Диагноз // Энциклопедический словарь Брокгауза и Ефрона : в 86 т. (82 т. и 4 доп.). — СПб., 1890—1907 <https://gufo.me/amp/dict/brockhaus/%D0%94%D0%B8%D0%B0%D0%B3%D0%BD%D0%BE%D0%B7>
4. Общество с ограниченной ответственностью «Смп-страхование» Правила страхования физических лиц от несчастных случаев от 27.03.2017
5. <https://www.smpins.ru/upload/iblock/16d/102%20%D0%9F%D1%80%D0%B0%D0%B2%D0%B8%D0%BB%D0%B0%20%D1%81%D1%82%D1%80%D0%B0%D1%85%20%D1%84%D0%B8%D0%B7%20%D0%BB%D0%B8%D1%86%20%D0%BE%D1%82%20%D0%BD%D1%81%20291217.pdf>
6. Официальный сайт Страховой компании “Согласие” <https://www.soglasie.ru/individuals/zdorovje/neschastnye-sluchai/>
7. Официальный сайт Страховой компании “Согласие” <https://www.soglasie.ru/individuals/zdorovje/neschastnye-sluchai/>
8. Официальный сайт «Страховой компании Райффайзен Лайф» <https://www.raiffeisen-life.ru/useful-info/yavlyayutsya-li-insult-i-infarkt-neschastnymi-sluchayami-pri-strakhovanii/>
9. Постановление Пленума Верховного Суда РФ от 10.03.2011 N 2 "О применении судами законодательства об обязательном социальном страховании от несчастных